# АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Төлөвлөгөөг хянасан:*
Авлигатай тэмцэх газрын дарга,
тэргүүн комиссар

*Төсвийн Ерөнхийлөн захирагч*
З.Дашдаваа

*Төлөвлөгөө баталсан:*
Тамгын хэлтсийн дарга,
эрхэлсэн комиссар

*Төсвийн Шууд захирагч*
З.Баасанням

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.01.07 Улаанбаатар хот

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Хариуцах нэгж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Төсөв |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Нэгдүгээр хэсэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| I. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| Гүйцэтгэлийн зорилт №1.1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх; | | | | | | | |
| 1. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1.1 дүгээр арга хэмжээ-Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох; /АТҮХт 4.1.1.1/ | ХШДШХ АБХШНА | Дүгнэлт нээлттэй, ил тод болжсон байна. | ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод болгох мэдээллийн хүрээ, хэлбэрийг тодорхойлох ажил хийгдэж байна Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болох ажлын хүрээнд мэдүүлэг гаргагч болон тухайн байгууллагын ЭБАТ-д ХАСУМ-ийг хянасан тухай АТГ-ын албан бичгийн огноо, дугаар, шийдвэрлэлтийн төлөвийг харагдахаар болгон цахим системд өөрчлөлт, хөгжүүлэлтийг хийсэн. | Эхний хагас жилд: ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг цахим системээс салбараар гаргах боломжийг АБХШНА-тай хамтран бүрдүүлэх, холбогдох мэдээллийг салбарын түвшинд олон нийтэд ил тод ажлыг эхлүүлэх;<br>Сүүлийн хагас жилд: ХАСУМ-ийг "Мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын цахим систем"-ийн хөгжүүлэлтийн төлөвлөгөө, ажлын даалгаврын хүрээнд холбогдох мэдээллийг ил тод болгох орчинг цахим системд бүрдүүлэх. | II- IV | |
| Гүйцэтгэлийн зорилт №1.2. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах; | | | | | | | |
| 2. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.1 дүгээр арга хэмжээ-Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх, нэгдсэн сан үүсгэх, сургалтад ашиглах;<br>/АТҮХт 4.1.5.4; 4.1.5.11/ | УССГХ | -Шүүхээр 2021 онд шийдвэрлэгдсэн хэргийн шийдвэрээр мэдээллийн сан үүсгэсэн байх;<br>-Шүүхийн шийдвэрүүдээс түүвэр хийж, /онцлог кэйс, жишээ баримттай/ 15-аас доошгүй шийдвэрийг олон нийтэд хүргэсэн байх<br>-Сургалт соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглаж, хэрэглээнд нэвтрүүлсэн байх; | Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах зорилгоор Албан тушаалын гэмт хэргийн 2011-2020 оны шүүхийн шийдвэрүүдийг эмхэтгэн хэвлүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2021 онд 2013, 2015, 2016, 2017 оны тус бүр 1 боть, нийт 5 боть хэвлүүлээд байна. 2019, 2020 оны шүүхийн шийдвэрийг эмхэтгэх ажил хийгдэж байна. 2011-2020 оны шүүхээр шийдвэрүүдэд хэргийн ба шүүгдэгчийн судалгаа гаргаж, нэгдсэн сан үүсгэн ажиллаж байна. | -2020-2021 онд авлигын хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрээр нэгдсэн сан үүсгэж, сургалт, бусад судалгаа дүн шинжилгээний ажилд ашиглах боломжтой болсон байна.<br>-Авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг иргэдэд ойлгомжтой байдлаар хураангуйлж, товчлол хийж олон нийтэд цуврал байдлаар хүргэх ажлыг зохион байгуулсан байх; | Жилдээ | |
| 3. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.2 дугаар арга хэмжээ Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах үйл ажиллагааны арга хэлбэрийг сайжруулах, иргэд, байгууллагаас өргөдөл, гомдол, мэдээлэл утсаар өгөх боломжийг бүрдүүлэх; /АТҮХт 4.1.5.5/ | США | -Үйл ажиллагаанд шинэ техник, технологи нэвтэрч, үйл ажиллагаа хөнгөвчлөгдөх нөхцөл бүрдсэн байх; | -Өргөдөл, гомдол, мэдээллийг тусгай дугаарын утсаар хүлээн авч, дүн шинжилгээ хийж байгаа. | -Өргөдөл, гомдол, мэдээлэл, тусгай дугаарын утас /110/-аар мэдээлэл хүлээн авах ажилд техник, технологи нэвтрүүлэх, яриаг бичвэрт хөрвүүлэх зэрэг технологийг судалж, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байх; | I-II | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.3 дугаар арга хэмжээ Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах; /Алсын хараа 2050-5.6.4, АТҮХт 4.1.5.7/ | ТХ | -Сургалт зохион байгуулагдсан байх;<br>-Өмнөх жилийн мөн үеэс сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо, сургалтын төрөл нэмэгдсэн байх; | Хүний нөөцийг чадавхижуулах, хандлага төлөвшүүлэх, мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх ажлын хүрээнд Удирдлагын академийн төрийн албаны сургуулиас зохион байгуулсан Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 5, Төрийн албанд шинээр томилогдсон алба хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3 албан хаагч суралцлаа. Мөн мэргэшил дээшлүүлэх институтээс зохион байгуулсанх Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны зайн сургалтад УССГХ-ийн 15, ХШДШХ-ийн 3, МШХ-ийн 2 алба хаагчийг, худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад 6, давтан сургалтад 4 албан хаагч суралцаж, гэрчилгээ авсан. Монгол Улсын Ерөнхий сайдын Ажлын алба, Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Сингапурын Үндэсний Их Сургууль (NUS), Удирдлагын академи хамтран зохион байгуулсан “Их өгөгдөлд суурилсан бодлогын инноваци” хөтөлбөрийн дагуу 2 өдрийн сургалтад 3, БХИС-ийн гадаад хэлний сургалтын төвд 1 албан хаагч хамрагдан суралцав. Албан хаагчдын гадаад хэлний сургадтад хамруулахаар Раффлес олон улсын сургалтын төвэй гэрээ байгуулсан бөгөөд сургалтын бэлтгэл ажлыг хангаж байна. ТАЗ-өөс злхион байгуулж байгаа сургалтад нэр бүхий албан хаагчид тогтмол хамрагдаж байна. | -АТГ-ын сургалтын хөтөлбөрт нийцүүлэн сургалтын төлөвлөгөө батлагдсан байх;<br>-Төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулагдсан байна. | I-IV | |
| 5. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.4 дүгээр арга хэмжээ-Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээллийн цахим санг хөгжүүлэх; /АТҮХт 4.1.5.7/ | АБХШНА УССГХ | -Хөтөлбөрийн хэрэгжилтийн 2021 оны мэдээллийг санд оруулах ажлыг зохион байгуулсан байх;<br>-Програм хангамжийг өргөтгөн дэд сангуудыг үүсгэх, хөгжүүлэлтийг хийсэн байх. | <u>“Ухаалаг засаглал ТББ-тай хамтран khutulbur.iaac.mn цахим</u> мэдээллийн санг хөгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд дараах 7 дэд санг үүсгэн холбогдох мэдээллийг оруулах ажлыг зохион байгуулж байна. Үндэсний хөтөлбөрийн дэд санд 2018, 2019, 2020 оны хэрэгжилтийн тайланг бүрэн оруулж дууссан бөгөөд 2022 оноос эхлэн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг цахимаар хүлээн авч үнэлэх боломж бүрдсэн. АТГ-ын Зөвлөмжийн биелэлт дэд санд 2021 оны 9 зөвлөмж, Мөрдөгчийн мэдэгдэл дэд санд 2020, 2021 оны 222 мэдэгдэл, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө дэд санд 2021 оны 21 аймгийн төлөвлөгөө, Хариуцлага тооцуулах, зөрчил арилгуулах дэд санд 82 байгууллага, албан тушаалтанд холбогдох мэдээлэл зэргийг тус тус оруулаад байна. Дүрэм, журам, тушаал, шийдвэрийн хяналтын систем буюу act.iaac.mn цахим санд байгаа нийт 95 мэдээлэл авлигын эсрэг Тушаал, шийдвэр, дүрэм, журам хянах дэд, шүүхийн шийдвэрийн дэд сангуудтай холбох, мэдээллийг шилжүүлэн оруулах ажлыг гүйцэтгэж байна. | 1 дүгээр улиралд-khutulbur.iaac.mn цахим мэдээллийг санд авлигын хэргийн шийдвэрлэлтийн болон авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, судалгааны шинжилгээний тоон мэдээ, мэдээллийг олон нийтэд танилцуулах зорилгоор “олон нийттэй харилцах цэс, олон нийтийн эрх” цэс үүсгэх асуудлаар санал боловсруулсан байна.<br>Жилдээ-khutulbur.iaac.mn цахим мэдээллийн сангийн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр дэд сан, мөрдөгчийн мэдэгдэл дэд сан, Зөвлөмжийн биелэлт дэд сан, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний, хариуцлага тооцуулах, зөрчил арилгуулах, тушаал, шийдвэр, дүрэм журам хянах дэд санг хөтлөх, act.iaac.mn цахим санд байгаа нийт 95 мэдээлэл”-ийг уг дэд сантай холбох, хөгжүүлэлтийг хийсэн байна. | I<br><br><br><br><br><br><br>I-IV | |
| 6. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.5 дугаар арга хэмжээ-Мэдээллийн нэгдсэн санд олон нийттэй харилцах цэс үүсгэж, хамрах хүрээг, үр нөлөөг нэмэгдүүлэх; | АБХШНА | -Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрийг мэдээлэх нэгдсэн санд олон нийттэй харилцах цэсийг үйл | Үндэсний статистикийн хорооноос 2019.12.26-ны өдөр А/196 дугаар тушаалаар олгосон зөвшөөрлийн дагуу АТГ-ын 2020.01.02-ны өдрийн А/02 дугаар тушаалаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 30, захиргааны 6 маягт, тэдгээрийг нөхөх заавар, өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэргийн шийдвэрлэлтийн, зүйлийн мэдээний маягт, заавар, | 1-р улиралд: -Мэдээллийн нэгдсэн санд олон нийттэй харилцах цэс үүсгэх судалгаа хийгдэж, техникийн болон бусад шийдлүүд гарсан байна.<br>-Ажлын даалгавар боловсрогдсон байх;<br>2-р улиралд: -Олон нийттэй харилцах цэсийг үүсгэж, туршилт хийгдсэн байх; | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | /АТҮХт 4.1.5.9/ | | ажиллагаанд нэвтрүүлсэн байх; | гэмт хэргийн тоо бүртгэлийн зааврыг тус тус баталгаажуулсан. Энэхүү маягт зааврын дагуу гэмт хэргийн шинжтэй гомдол, гэмт хэргийн мэдээллийн улсын албан ёсны статистикийг бүрдүүлж байгаа. 2021 онд Байгууллагад хүлээн авч хянан шийдвэрлэж байгаа өргөдөл гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг мессеж хэлбэрээр хүргэх технологийн шийдлийг боловсруулснаар тухайн өргөдөл, гомдол, мэдээлэл өгсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэн телефоны утсанд шийдвэрлэлтийн талаар 2 удаа мэдээллийг хүргэдэг болов | 3-4-р улиралд: -Үйл ажиллагаа хэвшсэн байх; | | |
| 7. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.6 дугаар арга хэмжээ-Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын давтан сургалтын болон хуульч бэлтгэдэг сургуулиудын сургалтын хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх талаар тусгасан эсэхэд дүн шинжилгээ хийх, тусгуулах арга хэмжээ авах; АТҮХ 4.1.5.12 | УССГХ | -Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын давтан сургалтын талаар эрх зүйн орчин, албан хаагчдыг давтан сургах үйл ажиллагааны төлөвлөлт, баримталж буй бодлого, тэдгээрийн хэрэгжилтийг судалсан байх,<br>-Санал боловсруулсан байх | Улсын Ерөнхий Прокурорын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар батлагдсан “Прокурорын байгууллагын сургалтын талаар баримтлах үзэл баримтлал”-ыг хэрэгжүүлэх 2020-2024 оны төлөвлөгөөнд “Авлига, албан тушаалын гэмт хэрэгт тавих прокурорын хяналт” сэдэвт сургалтыг тусгуулав. ХЗДХС-ын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/131 дүгээр тушаалаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний болон онцгой байдлын байгууллагын тасгийн дарга буюу түүнтэй адилтгах албан тушаалтны нөөцөд авагдсан албан хаагчдын “Албан тушаалын дамжаа”-ны болон удирдах ажилтны давтан сургалтын хөтөлбөрт “Авлигатай тэмцэхэд төрийн албан хаагчийн үүрэг, хариуцлага” сэдэвт 4 цагийн сургалтыг тусгуулсан. | 1-2 дугаар улиралд:<br>-Эрх зүй, хууль сахиулах чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй сургуулиудын сургалтын хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сэдэв, агуулга тусгасан байдалд дүн шинжилгээ хийх, хөтөлбөрт тусгуулах агуулга, сэдвийн загвар боловсруулах ажлыг зохион байгуулах<br>-Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудын сургалтын хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгасан байдалд дүн шинжилгээ хийж, санал боловсруулах, эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах;<br>2-3 дугаар улиралд:-Дүн шинжилгээнд тулгуурлан сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар сэдэв, агуулгыг тусгуулах талаар зөвлөмж хүргүүлсэн байх; | I-III | |
| 8. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.7 дугаар арга хэмжээ-Хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоож, мөрдөх; /АТҮХт 4.1.5.13; 4.1.5.14, СТ С3-3.7/ | ХШДШХ | -УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 5, 20 дугаар тогтоолд оруулах шинэчилсэн найруулгын төслийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилсан байна.<br>-Батлагдсан тохиолдолд сурталчилгааг зохион байгуулсан байна. | УИХ-ын ХЗБХ-ны 2014 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалтны жагсаалт”-ыг шинэчилсэн төслийн эцсийн хувилбарыг боловсруулсан. АТГ-ын Газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2021 оны 4 дүгээр улиралд Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компани, аж ахуйн нэгж, түүний харьяа хараат болон охин компани нийт 74 компанийн ажилтнуудын ажлын байрны чиг үүрэгт дүн шинжилгээ хийж авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлтэй 404 албан тушаалтныг Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамруулахаар холбогдох байгууллагуудад бичгээр зөвлөмж хүргүүлэв. | Хагас жилд-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 5, 20 дугаар тогтоолын шинэчилсэн найруулгын зохих нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилсан байна.<br>Сүүлийн хагас жилд-Сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулах. | I-IV | |
| 9. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.8 дугаар арга хэмжээ-Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргах тогтолцоог бүрдүүлэх /АТҮХт 4.1.5.16/ | УССГХ ТХ | -Санал зөвлөмж гаргах үндэслэл, журмын талаарх саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилсан байх; | -Авлигын эсрэг хуулийн 6.1.9-д зааснаар төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө АТГ-аас санал авахаар тусгагдсан.<br>-Захиргааны хэм хэмжээний актын төслийг батлуулахаас өмнө АТГ-аас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмжийг авдаг байхаар буюу Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэгт оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг ХЗДХЯаманд уламжилсан. | I-II улиралд-Санал зөвлөмж гаргах үндэслэл, журмын төслийг боловсруулж, саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилсан байх; | I-II | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Гүйцэтгэлийн зорилт №1.3 Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах; /Алсын хараа 2050-5.6.5/ | | | | | | | |
| 10. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.3.1.1 дүгээр арга хэмжээ-Хувийн хэвшлийн байгууллагуудын чадавхжуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах; /АТҮХт 4.1.6.1/ | УССГХ | -Сургалт зохион байгуулж, үр дүнг тооцсон байх; | Хувийн хэвшлийн байгууллагуудад зориулсан сургалтын хөтөлбөрийг шинэчлэн, туршилтын сургалт зохион байгуулсан. Уг сургалтад Шунхлай ХХК-ийн компанийн 85 ажилтан, “Зориг сан”гийн сурагчдыг чадавхжуулах хөтөлбөрт хамрагдсан 21 сурагч, нийт 3 удаагийн сургалтад 241 хүн хамрагдав. МҮХАҮТ-ын дэргэдэх “Бизнесийн ёс зүйн төв”-ийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллаж, хувийн хэвшлийн бизнесийн ёс зүй, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг хамтран зохион байгуулав. Энэ хүрээнд 2 удаагийн сургалтаар 100 гаруй хүнийг хамруулав. Мөн “Хувийн хэвшилд зориулсан авлигаас урьдчилан сэргийлэх 9 зөвлөмж”, “Шударга ёс, хөгжил дэвшилд хувийн хэвшлийн оролцоо” гарын авлагыг аж ахуйн нэгжүүдэд түгээлээ. АТГ-аас 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан “Авлигын эсрэг үндэсний чуулган 2021” чуулганд “Хувийн хэвшил ба шударга өрсөлдөөн” салбар хэлэлцүүлэг зохион байгуулж, төр хувийн хэвшлийн түншлэл, бизнесийн орчны шударга байдлыг сайжруулах, авлигаас ангид, шударга өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр илтгэл хэлэлцүүллээ. Хувийн хэвшилд зориулсан ашиг сонирхлын зөрчлийн 12 төрлийн хориглолт, хязгаарлалтын тухай 5 модуль бүхий интерактив хичээл боловсруулж, жүжигчилсэн хэлбэртэй зохиол болгож, интерактив сургалтын модулийг програм хангамж руу буулгаж, аппликейшн бүтээх гүйцэтгэгчийн талаарх судалгааг хийж байна. | 1 дүгээр улиралд-Хувийн хэвшилд зориулсан шударга өрсөлдөөн, бизнесийн ёс зүйн сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын судалгаа гаргах, хамтран ажиллах талаар санал солилцох уулзалт зохион байгуулсан байна.<br>-Хувийн хэвшлийн байгууллагад зохион байгуулах сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулсан байна.<br><br>Жилдээ -Сургалтыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, сургалтын үр дүнг тооцсон байх;<br><br>-Хөтөлбөрийн уг заалтыг хэрэгжүүлэгч байгууллагууд (ШӨХТГ, МХЕГ, ГЕГ, ТЕГ, СХЗГ, УБЕГ, МҮХАҮТ, МАОЭНХ, МБЗ)-тай хамтран ажиллаж, | I-IV | |
| Гүйцэтгэлийн зорилт №1.4 Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр /Алсын хараа 2050-5.6.5/ | | | | | | | |
| 11. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.4.1.1 дүгээр арга хэмжээ-Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах; /АТҮХт 4.1.7.1/ | УССГХ<br>США | Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийлгэсэн байх; | 2020 онд “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт” сэдэвт цахим хэлэлцүүлэг, “Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг хөндлөнгийн шинжээчдээр гүйцэтгүүлж, тайланг танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулсан. Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээнд гарсан үр дүн, үр нөлөөнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг иргэний нийгмийн байгууллагуудаар хэлэлцүүлэх чиглэлээр Монголын хуульчдын холбоо, “Баасанжав Консалтанг” ХХК-тай хамтран ажиллав. | 1 дүгээр улиралд-Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах<br>2 дугаар улиралд-Үнэлгээний үр дүнг олон нийтэд танилцуулах, хэлэлцүүлэг зохион байгуулах, үр дүнд тулгуурлан холбогдох арга хэмжээний санал боловсруулж, хэрэгжүүлэх | I-II | |
| 12. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.4.1.1 дүгээр арга хэмжээ-Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл | УССГХ | -Авлигын эсрэг хууль тогтоомж, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон тэдгээр нийцүүлэн гаргасан дүрэм, журамд | Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээний санал, чиглэлийг хүргүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хамтарч ажиллах талаар санал солилцож, нэгдсэн мэдээлэл арга зүйгээр хангах | 1, 2 дугаар улиралд:-Аймгийн ГХУСАЗСЗ-д санал, чиглэл хүргүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах онлайн уулзалтыг зохион байгуулсан байна.<br><br>Жилдээ-Бэлтгэгдсэн сургагч багш нарыг чадавхжуулах, тэднээр дамжуулан орон нутгийн иргэдэд авлигаас | I-II<br><br>I-IV | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | өгөх, хамтран ажиллах; /АТҮХт 4.1.7.1/ | | заасан шаардлагыг хангасан байна.<br>-Нийслэл, орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, үр дүн нэмэгдсэн байна. | зорилгоор уулзалт зохион байгуулав. ГХУСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд, мөн Нийслэлийн ГХУСЗ-ийн 2021 оны төсөв, төлөвлөгөөний төсөлд авлигын эсрэг болон авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны саналыг тусгуулсан. Аймгийн ГХУССЗ-ийн 37 ажилтныг авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийн 5 удаагийн сургалтад хамруулж, гэрчилгээ олгон, сургагч багш нараас 2021 онд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын нэгдсэн жишиг төлөвлөгөөг боловсруулж, 21 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэв. ГХУСАЗСЗ-ийн дарга, гишүүдтэй цахим уулзалтыг зохион байгуулж, 21 аймгийн ГХУСАЗЗ-ийн авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлыг эрчимжүүлэх, цаашид хэрхэн хамтарч ажиллах талаар санал солилцож, нэгдсэн мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллав. | урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтран ажилласан байна.<br><br>ГХУСАЗЗ, аймаг, нийслэлийн ГХУСАЗСЗ-тай харилцах, хамтран ажиллах, төлөвлөгөө, тайлан мэдээ гаргасан байна. | Тухай бүр |
| Гүйцэтгэлийн зорилт №1.5 Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах; | | | | | | |
| 13. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.5.1.1 дүгээр дугаар арга хэмжээ-Баримтад суурилсан сэтгүүл зүйг хөхиүлэн дэмжих, сэтгүүлчдийн цахим орчинд мэдээлэл олж авах чадавхыг нэмэгдүүлэх; /АТҮХт 4.1.8.1-1/ | УССГХ | -Сургалт зохион байгуулсан байх | 2021 онд энэ төрлийн сургалт зохион байгуулагдаагүй. | 1 дүгээр улиралд-Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдэд нээлттэй мэдээлэлтэй ажиллах, хяналт тавих чиглэлээр 2 удаагийн сургалт зохион байгуулсан байх; | I |
| 14. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.5.1.2 дугаар арга хэмжээ-Эрэн сурвалжлах сэтгүүлч, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлд сургалт зохион байгуулах; /АТҮХт 4.1.8.1-1/ | УССГХ | -Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлд зориулсан сургалт зохион байгуулсан байх;<br>-Эрэн сурвалжлах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сурвалжлагч, сэтгүүлч нарт зориулсан сургалт зохион байгуулсан байх. | Цар тахлын улмаас тогтоосон хөл хорионы улмаас сэтгүүлчдийг оролцуулсан сургалт, хэлэлцүүлэг хийгдээгүй болно. | 1-р улиралд: Сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байна.<br>2-р улиралд: Сэтгүүлчдийн мэргэжлийн холбоод, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран эрэн сурвалжлах чиглэлээр мэргэших сонирхолтой залуу сэтгүүлчдэд сургалт зохион байгуулсан байна. | I |
| Гүйцэтгэлийн зорилт №1.6 Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах зорилтыг хангах; /Алсын хараа 2050-5.6.2/ | | | | | | |
| 15. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.6.1.1 дугаар арга хэмжээ-Улс төрийн намын удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх; ХАСХОМ-ийг олон нийтэд мэдээлэх; /АТҮХт 4.1.9.6/ | ХШДШХ | Улс төрийн намын удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих зохицуулалтын талаар судалгаа хийж, санал боловсрогдсон байна. | УИХ-ын ХЗБХ-ны 2014 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалтны жагсаалт”-ыг шинэчлэх ажлын хүрээнд төслийг боловсруулав. Уг төсөлд Улсын Их Хуралд суудалтай намын дарга, дэд дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга, Ажлын албаны дарга, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх нам, эвслийн бүлгийн Ажлын албаны дарга ХАСХОМ мэдүүлэх байдлаар тусгаад байна. | 2-р улиралд: Санал боловсрогдож, эрх бүхий байгууллагад уламжлах нөхцөл бүрдсэн байна.<br>3-р улиралд: Батлагдсан тохиолдолд мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан байна. | II-III |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Гүйцэтгэлийн зорилт №1.7 Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах; | | | | | | | |
| 16. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1.1 дүгээр арга хэмжээ-Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах; /Алсын хараа 2050-5.6.1, 2, АТҮХт 4.1.10.1-1, АЭХ 18.1.5/ | УССГХ | -Сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байх, биелэлтийг тооцсон байх;<br><br>-Шударга ёсны клубын үйл ажиллагааг идэвхжүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсан байх;<br><br>-Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын идэвх оролцоог хангах, өргөжүүлэх арга хэмжээ авсан байх;<br><br>-Олон талт арга хэмжээг төлөвлөгөө гарган зохион байгуулж, үр дүн тооцсон байх; | Авлигын хор хөнөөл, шударга зүйлд иргэд, олон нийт, төрийн албан хаагчдыг уриалах, авлигын эсрэг үйл ажиллагаанд тэдний татан оролцуулах зорилгоор радио, телевизтэй хамтран ажиллаж, сурталчилгааг тасралтгүй, тогтмол явуулж байна. "Шударга ёсны боловсрол" хөтөлбөрийн хүрээнд бэлтгэсэн ЕБС-ийн багш нар нийт 20892 хүүхэд, 332 эцэг эхэд буюу нийт 25704 иргэн, албан хаагч, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, эцэг эхэд сургалт зохион байгуулсан байна. Авлигын эсрэг сургалтад хамрагдсан нийт хүний тоо өмнөх оноос 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2020 онд боловсрол, эрүүл мэнд, уул уурхай, хууль зүй, сэтгүүл зүйн салбарын иргэний нийгмийн байгууллагын сургагч багш бэлтгэх анхан шатны сургалтад хамрагдсан албан хаагчдыг чадавхжуулах давтан сургалтыг зохион байгуулж, болзол хангасан багш нарт гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулав. Соён гэгээрүүлэх ажлыг зорилтот бүлгүүдэд чиглүүлж олон төрөл хэлбэрээр зохион байгуулав. Нийслэлийн ерөнхий боловсролын 12, 24, 32, 40, 84 дүгээр сургуульд "Шударга ёсны клуб"-ыг байгуулж, үйл ажиллагааг албан ёсоор нээсэн. Видео шторк, контентыг арилжааны 12 телевиз, орон нутгийн 24 телевиз, "АТГ-Олон Нийтийн Төв" пэйж хуудсаар болон "IAAC Mongolia youtube" хуудсаар дамжуулан түгээж, олны хүртээл болгов. "АТГ-Олон нийтийн Төв" пэйж дагагчдын тоо 10126-аар, "IAAC Mongolia youtube" хуудас захиалагчдын тоо 67.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор 46 видео, контент, шторк бүтээж, олон нийтийн сүлжээ, радио, телевизээр тасралтгүй сурталчлан түгээж ажиллалаа. | Жилдээ-Иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг тасралтгүй, шинэлэг хэлбэрээр зохион байгуулсан байна.<br><br>"Шударга ёсны клуб"-ын үйл ажиллагааг идэвхжүүлэн, шударга ёсны ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан байх; | I-IV<br><br>I-IV | |
| 17. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1.2 дугаар арга хэмжээ-Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны материал боловсруулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулахад иргэн, төрийн бус байгууллагыг татан оролцуулах;<br>/АТҮХт 4.1.10.1-2/ | УССГХ | -Авлигын эсрэг сурталчилгааны материалыг хэвлэмэл, аудио, видео гэсэн 3 үндсэн нэр төрлөөр бэлтгэсэн байх;<br>-Сурталчилгааны материалыг шууд 5000 хүн, шууд бусаар 100.000 хүнд хүргэсэн байх. | 2021 онд Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг ухуулан сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг тайлбарлан таниулах зорилгоор "Аавын захиас", "Тангараг" "Өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр", "Шударга ёс гэж юу вэ?" сэдэвт богино хэмжээний 4 кино контент, гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын утсыг сурталчилсан 2 төрлийн шторкийг бүтээв. Хүүхэд багачуудад бага балчир наснаас нь шударга ёсны талаар ойлголт өгөх, шударга үйлдэл, дадал хэвшилтэй болгох зорилгоор Улсын Хүүхэлдэйн театртай хамтран "Бүлтээхэй, дэлдээхэй хоёрын шударга тоглоом" теле жүжгийг бүтээж, телевиз, цахим мэдээллийн сувгаар олон нийтэд түгээх ажлыг зохион байгууллаа. Нийт 4 төрлийн сурталчилгааны материал, 6 төрлийн зурагт хуудсыг эрхлэн хэвлүүлж, сургалт, сурталчилгааны ажилд ашиглуулахаар төв, орон нутаг, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж номын сангуудад түгээж байна. Түүнчлэн нийслэлийн 5 дүүрэгт байрлах мэдээллийн | I улиралд-Сургалтын хэрэглэгдэхүүн шинээр боловсруулж, сургалтад ашигласан байх;<br><br>-Сурталчилгааны материал боловсруулж, баталгаажуулсан байх;<br><br>Жилдээ-Түгээлтийг хийсэн байх;<br><br>Иргэн, төрийн бус байгууллагыг татан оролцуулсан байх; | I<br><br><br>I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | самбар, орон сууцны лифтэнд сурталчилгаа байршуулах зэрэг ажлыг зохион байгуулав. | | | |
| 18. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1.3 дугаар арга хэмжээ-Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулах чиглэлээр аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллах; /АТҮХ т4.1.10.1-3/ | УССГХ | -Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлыг тогтмолжуулж, эргэх холбоо үүсгэсэн байх;<br>-Иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнг үнэлж дүгнэсэн байх. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлын механизмыг бүрдүүлэх хүрээнд Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвийн ажилтнуудын судалгааг авч, 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн ИТХ, ЗДТГ-т хамтран ажиллах чиглэлээр "САНАЛ" хүргүүлснээр хамтран ажиллах суурь нөхцөл бүрдсэн.<br>Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний танхим, Хууль зүйн туслалцааны төвийн 65 ажилтантай хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд Авлигатай тэмцэх газраас эрхлэн гаргасан ном, гарын авлага, сурталчилгааны материал, зурагт хуудас, видео контент, шторкийг хүргүүлж, албан ёсны цахим хуудас, группээр дамжуулан сурталчилж, зохион байгуулсан ажлын тайланг хүлээн авч, нэгтгэн дүгнэв. Иргэний танхим, Хууль зүйн туслалцааны төвүүд нь авлигын эсрэг хууль тогтоомжийг давхардсан тоогоор 851130 иргэнд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан байна. | Жилдээ-Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний танхим болон Хууль зүйн туслалцааны төвтэй соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж,, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байна.<br><br>Сар тутамд-Төрийн байгууллагуудад байршуулсан "Шударга ёс, хөгжил дэвшилд" самбарт мэдээлэл тогтмол байршуулсан байна.<br><br>Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллаж үр дүнг тооцсон байна. | I-IV | |
| 19. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1.4 дүгээр арга хэмжээ-Төрийн байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах; /АТҮХт 4.1.10.1-4, АЭХуулийн 18.4.1/ | УССГХ | -Төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийг цахим санд оруулсан байх;<br>-Үнэлгээ цахим хэлбэрээр хийж хэвшсэн байх;<br>-Төлөвлөгөө хэрэгжүүлэгч байгууллагын тоог нэмэгдүүлсэн байх. | -Төрийн байгууллагуудад нийтлэг байдлаар хэрэгжүүлэх авлигын эсрэг төлөвлөгөөний загвар санал, түүний үр дүнг тооцох дүгнэх хуудас боловсруулан хүргүүлсэн.<br>-Авлигын эсрэг үндэсний сүлжээ цахим мэдээллийн санд "Авлигын эсрэг төлөвлөгөөний дэд сан" үүсгэж, мэдээлэл хэрхэн оруулах, цахим санд хүлээн авах, дүгнэх сургалт, хэлэлцүүлгийг 2021.05.28-нд зохион байгуулсан.<br>-2021 онд УИХ-ын харьяа 7 байгууллага, 14 яам, 34 агентлаг, аймаг, нийслэл 22, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 6, нийт 85 байгууллага төлөвлөгөө батлан хэрэгжүүлсэн. | 1 дүгээр улиралд-Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны биелэлтийг үнэлэх, үнэлгээний дүнг олон нийтэд танилцуулсан байх;<br>7 дугаар сард-Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд эхний хагас жилийн байдлаар дүн шинжилгээ хийсэн байх;<br>Жилдээ-Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлийг хангуулах, эрчимжүүлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн байх; | I<br><br>VII сарл<br><br>I-IV | |
| 20. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1.5 дугаар арга хэмжээ-Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах; /АТҮХт 4.1.10.2-3/ | УССГХ | -Өдөрлөг, сургалт, хэлэлцүүлэг, уралдаанд оюутан, сурагч, эцэг эхийг хамруулсан байх;<br>-Өдөрлөг, сургалт, хэлэлцүүлэг, уралдаан бүрийн төгсгөлд сэтгэл ханамжийн судалгаа хийж, дүгнэсэн байх. | "Зөв дадал-21" арга хэмжээг зохион байгуулж, олон нийтийн сүлжээгээр түгээв. "Шударга ёсны боловсрол: Гэр бүл, хүмүүжил, төлөвшил" чөлөөт уулзалтыг зохион байгуулав. Уулзалтад нийслэлийн 6 дүүргийн 12 сурагч, эцэг, эхийн хамт нийт 36 хүн оролцлоо.<br>"Шударга ёсны боловсрол" (авлигатай тэмцэх, үнэт зүйлс болон хууль дээдлэх талаар боловсрол олгох нь) хөтөлбөрийг 2 үе шаттай зохион байгуулсан. I үе шатанд "Шударга ёсны боловсрол" гарын авлагын дагуу хичээл заах багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, Нийслэлийн төрийн өмчийн 29 дунд сургуулийн 35 багшийг хамруулав. Хоёрдугаар үе шатанд сургалтад хамрагдсан багш нар өөр өөрсдийн сургууль дээр багш бэлтгэх сургалтыг зохион байгуулснаар нийслэлийн Ерөнхий боловсролын дунд сургуулийн 827 багшийг хамруулснаар нийт 20892 хүүхэд, 332 эцэг эх тус сургалт зохион байгуулсан байна. Их, дээд сургуулийн оюутнуудад шударга ёсны талаарх үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох, авлигын эсрэг дуу хоолойг сонсох, санал санаачилгыг дэмжин хэрэгжүүлэх зорилгоор чөлөөт | 2, 4 дүгээр улиралд-Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байх; | II, IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ярилцлага өрнүүлэх “Таны эрх, таны оролцоо: Залуучууд авлигыг тэвчихгүй” нээлттэй өдөрлөгийг 4 үе шаттай зохион байгууллаа. | | | |
| 21. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1.6 дугаар арга хэмжээ-Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлаар нийтийн албан тушаалтан, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, сургалтыг шинэлэг арга хэлбэрээр үе шаттай зохион явуулах; /АТҮХт 4.1.10.3, С2-2.10, С2-2.4/ | УССГХ | -Иргэдэд зориулсан авлигын эсрэг мэдлэг, ойлголт олгох гарын авлагыг боловсруулж хэвлүүлсэн байх;<br>-Гарын авлагыг иргэдэд хүргэж, хэлэлцүүлэн, үр дүнг үнэлсэн байх;<br>-Хөтөлбөр, гарын авлага боловсруулах, хэвлүүлэх ажлыг зохион байгуулсан байх;<br>-Сургалтын хөтөлбөр, модулийг туршсан байх. | Иргэдэд зориулсан авлигын эсрэг мэдлэг, ойлголт олгох сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, хэвлүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор сургалтад хамрагдагсдаас санал асуулга авч нэгдсэн жагсаалт гаргав. Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2020, Авлигын гэмт хэргийг 2013, 2015, 2016, 2017, 2018 онд хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл, “Зөв зөвд шударга зөв”, “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч танаа”, “Шударга ёсны боловсрол”, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга танаа” зэрэг 16 гарын авлагыг эрхлэн хэвлүүллээ.<br>Хувийн хэвшлийн ажилтнуудад зориулсан ашиг сонирхлын зөрчлийн 12 төрлийн хориглолт, хязгаарлалтын тухай 5 модуль бүхий интерактив хичээлийн модулийг туршилт байдлаар боловсруулсан. “Шударга ёс-Иргэний хяналт” чадавхжуулах сургалтын хөтөлбөр (14.75 хэвлэлийн хуудас) боловсруулж, уг хөтөлбөрийг 3 өдөрт багтаан хэрэгжүүлэх 9 цагийн лекц, 9 цагийн дасгал, 3 цагийн хэлэлцүүлгээс бүрдсэн, хөтөлбөрийг боловсруулж, туршилт сургалт хийн баталгаажуулсан.<br>-2021 онд 134 удаагийн авлигын эсрэг сургалт зохион байгуулж, 27.304 нийтийн албан тушаалтныг хамруулсан. | Авлигын эсрэг сургалтын 5 модуль, Авлигын эсрэг үндэсний чуулганы илтгэл, шүүхийн шийдвэрийн 2019-2021 оны эмхэтгэл, хүүхдүүдийн илтгэл, төрийн албан хаагчдад зориулсан гарын авлага, иргэдэд зориулсан товхимол зэрэг 10 ном, гарын авлагыг бэлтгэн, түгээсэн<br>1 дүгээр улиралд-Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зохицуулалтыг тайлбарласан комикс цувралыг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байх;<br>-Төрийн бус байгууллагад зориулсан гарын авлага боловсруулсан байх;<br>1-2 дугаар улиралд-Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд шударга ёсны сэдэвт сургалтын хөтөлбөр, боловсруулах уралдааныг зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;<br>-Хүүхэд залуучууд, төрийн өмчит хуулийн этгээдэд зориулсан гарын авлага-товхимол боловсруулах, түгээх, танилцуулах арга хэмжээ зохион байгуулсан байх;<br>2-3 дугаар улиралд-Хувийн хэвшилд зориулсан сургалтын гарын авлага боловсруулж хэвлүүлсэн байх;<br>1 дүгээр улиралд-2018-2021 онд сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгааг гаргасан байх;<br>2022 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр батлагдсан байх;<br>Жилдээ-Сургалт зохион байгуулагдсан байх; | I-IV<br>I<br>I-II<br>II-III<br>I<br>I-IV | |
| 22. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1.7 дугаар арга хэмжээ-Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх; /АТҮХт 4.1.10.4, С2-2.12/ | УССГХ | -Өмнөх жилүүдэд бэлтгэсэн сургагч багш нарын бүртгэлийг шинэчилж, сургалт, сурталчилгаа хийлгэх ажлыг эрчимжүүлсэн байх;<br>-Сургагч багш бэлтгэх шаардлага салбар, зорилтот бүлгээс сургагч багш шинээр бэлтгэж чадавхжуулсан байх;<br>-Сургагч багш нарын хийсэн сургалт, сурталчилгааны too, хамрагдсан хүмүүсийн талаар мэдээллийг нэгтгэн үр дүнг тооцсон байх; | Аймгийн ГХУСАЗЗ-ийн 37 ажилтныг авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийн 5 удаагийн сургалтад хамруулж, гэрчилгээ олгон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн сургагч багш нараас 2021 онд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын нэгдсэн жишиг төлөвлөгөөг боловсруулж, 21 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүргүүлэв. 2020 онд боловсрол, эрүүл мэнд, уул уурхай, хууль зүй, сэтгүүл зүйн салбарын иргэний нийгмийн байгууллагын сургагч багш бэлтгэх анхан шатны сургалтад хамрагдсан албан хаагчдыг чадавхжуулах давтан сургалтыг зохион байгуулж, болзол хангасан багш нарт гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулав.“Шударга ёсны боловсрол” хөтөлбөрт хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдсэн нийслэлийн төрийн өмчийн 29 дунд сургуулийн 35 багш өөр өөрсдийн сургууль дээр багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, | Жилдээ-Өмнө бэлтгэсэн сургагч багшийг чадавхжуулах давтан вакумжуулсан сургалтыг зохион байгуулсан байна.<br>-Сургагч багш бэлтгэх шаардлагатай салбар, чиглэлийг тодорхойлж, сургагч багш бэлтгэсэн байна.<br>-Сургагч багш нараар дамжуулан авлигын эсрэг сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна.<br>-Шударга ёсны боловсрол олгох хөтөлбөрийг Боловсрол хамтын ажиллагааны нийгэмлэг, иргэний нийгмийн байгууллагатай хамтран сургагч багшийг бэлтгэсэн багш нараар дамжуулж сурагч, эцэг эхэд шударга ёсны талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, уг арга хэмжээг орон нутагт өргөжүүлсэн байна. | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -Бага дунд сургуулийн багш нараас сургагч багш бэлтгэх;<br>-Нийслэл, орон нутгийн ГХУСАЗЗ-д сургагч багш бэлтгэх;<br>-Сургагч багш нараар дамжуулан авлигын эсрэг сургалт, сурталчилгааны ажлыг хийж, үр дүнг тооцсон байна. | 827 багш бэлтгэснээр нийт 20892 хүүхэд, 332 эцэг эх тус сургалтад хамрагдсан дүнтэй байна.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилт, чиглэлийг хэрэгжүүлэхээр аймгийн ГХУСАЗЗ-ийн 37 ажилтныг авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийн 5 удаагийн сургалтад хамруулж, гэрчилгээ олголоо. | | | |
| Гүйцэтгэлийн зорилт №1.8 Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх зорилтыг хангах; | | | | | | | |
| 23. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.8.1.1 дүгээр арга хэмжээ-Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын өөрийн үнэлгээний тайлан боловсруулж, хүргүүлэх, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах; /АТҮХт 4.1.11.2-1/ | УССГХ<br>ТХ | -Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 2, 5 дугаар бүлгийн хэрэгжилтийн тайлангийн төсөлд санал бэлтгэж дуусгасан байх;<br>-Энэхүү тайланг хамгаалах ажлыг НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх албанаас өгсөн чиглэлийн дагуу зохион байгуулсан байх;<br>-Ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан байх. | НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төсөлд нэмэлт санхүүжилт хүссэн хүсэлтийг шийдвэрлүүлж, Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцын үнэлгээний тайлангийн төсөлд нэмж оруулах мэдээллийг бэлтгэх ажлын хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэлэлцээрийн холбоо хамаарал, хууль сахиулагч этгээдүүд, хууль тогтоомжийн төрлийн талаар мэдээлэл боловсруулав. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн товч танилцуулгыг бэлтгэсэн. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцын хэрэгжилтийн тайланг боловсруулж байна. Тухайлбал, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын үнэлгээний тайлангийн төсөлд Авлигатай тэмцэх үйл ажиллагаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн тухай мэдээлэл шинээр бэлтгэж оруулав. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцын 2, 5 дугаар бүлгийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээний тайлан хамгаалах бэлтгэл ажлыг хангаад байна. | Жилдээ-Авлигын эсрэг НҮБ-ын конвенц болон Авлигын эсрэг үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг дотоод, гадаадын болон олон улсын байгууллагад хугацаанд нь тогтмол хүргүүлсэн байна.<br>-Тайланг хүргүүлэх, хамгаалах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг НҮБ-аас өгсөн чиглэлийн хүрээнд зохион байгуулсан байна.<br>-Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авсан байна. | I-IV | |
| 24. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.8.1.2 дугаар арга хэмжээ-ЭЗХАХБ-ын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээ байгууллагаас Авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаар ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллах; /АТҮХт 4.1.11.2-1/ | ТХ | -Зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулсан байх.<br><br>-Тайланг хамгаалсан байх;<br><br>-Цаг үеийн асуудлаар тус байгууллагатай тухай бүр хамтран ажилласан байх. | Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр төрийн болон ТББ-тай хамтран ажиллаж, арга зүйн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллав. Уг зөвлөмжийг 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авахыг хэрэгжүүлэгч гол гол байгууллагуудад мэдэгдсэн. Мөн “Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг тайлан боловсруулах хуваарийг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Авлигын эсрэг сүлжээ нь 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдөр 26 дахь удаагийн Удирдах зөвлөлийн уулзалтаа зохион байгуулж, уг уулзалтад оролцогчдод Дээд түвшний авлигын гэмт хэргийн талаарх матрикс судалгааны аргачлалын төсөлд тусгуулах саналыг боловсруулж байна. | Жилдээ-Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн байгууллагуудаас мэдээлэл, тайлан, судалгаа гаргуулан авч нэгтгэж, хэрэгжилтийг хангах, уулзалт зохион байгуулах, санал, зөвлөмж боловсруулах зэргээр арга хэмжээг зохион байгуулах, хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлсэн байна. | I-IV | |
| 25. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.8.1.3 дугаар арга хэмжээ-Монгол Улсын хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдын чадавхыг сайжруулах чиглэлд Дэлхийн | ТХ | -Дэлхийн банкны Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилга (StAR), Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран | Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис гэмт хэрэгтэй тэмцэх албаны Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилга (StAR)-тай хамтран албан хаагчдын чадавх сайжруулах ажлын хүрээнд СтАР санаачилгын баг болон тус санаачилгын Монгол Улс дахь үйл ажиллагааг санхүүжүүлж буй Төрийн Департментыг төлөөлсөн АНУ- | Жилдээ-Хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулагдсан байна.<br><br>-Санхүүгийн мөрдлөг курсыг 3 байгууллагын 60 албан хаагчийг хамруулан зохион байгуулах | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | банкны Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилга (StAR), Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах; /АТҮХт 4.1.11.2-4/ | | АТГ-ын мөрдөгчийн албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр батлагдсан байх;<br>-Сургалтын бэлтгэл ажлыг хариуцан зохион байгуулсан байх;<br>-Суралцуулах албан хаагчдын нэрс тодорхой болж сургалтад хамруулсан байх;<br>-Сургалтын үр дүнгийн талаар санал асуулга авч, дүгнэсэн байх;<br>-Сургалт, сургалтын үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулсан байх, гарсан шийдвэрийг хэрэгжилтийг зохион байгуулсан байх; | ын ЭСЯ-нд сургалтын хэлбэр, агуулгыг өөрчлөх талаарх саналыг хүргүүлэв. Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, Европын гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилгатай хамтран 2 дугаар сарын 18-ны өдөр “Иргэний нэхэмжлэлээр олон улсад хөрөнгө хураах ажиллагаа” сэдэвт цахим сургалтад ГАХ, МШХ-ийн 65, 2021 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр “Криптовалют ба түүний онцлог”, 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдөр “Удиртгал хичээл-Дарквеб” семинарт АТГ, ЦЕГ, УЕПГ-ийн 400, 2021 оны 11 дүгээр сарын 9-нөөс 12 дугаар сарын 8-ны өдрүүдэд зохион байгуулсан “Санхүүгийн мөрдлөг” сургалтад АТГ, ЦЕГ, УЕПГ-ын 24 албан хаагчийг хамруулав. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн европ, төв азийн авлигын эсрэг сүлжээ, Ази номхон далайн орнуудын авлигын эсрэг сүлжээ, ОХУ-ын Засгийн газрын дэргэдэх Санхүүгийн их сургууль, Авлигын эсрэг олон улсын академи, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хороо, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба зэрэг гадаад улсын болон олон улсын байгууллагаас зохион байгуулсан авлигаас урьдчилан сэргийлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэг мөрдөн шалгах чиглэлийн сургалтуудад давхардсан тоогоор байгууллагын 120 гаруй албан хаагч, бусад хууль сахиулах байгууллагын 555 албан хаагчийг хамруулав. | -3 удаагийн богино хугацааны цахим сургалт зохион байгуулсан байна. | | |
| Гүйцэтгэлийн зорилт №1.9 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааны тайлан мэдээ хүлээн авах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нэгдсэн тайлан боловсруулж, хүргүүлэх; | | | | | | | |
| 26. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.9.1.1 дүгээр арга хэмжээ-Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг холбогдох газарт хүргүүлэх; /МУХ5жҮЧ-5.6.3, МУЗГҮАХ, АТҮХ 8.2/ | УССГХ | -Үнэн, зөв үнэлсэн байх;<br>-2021 оны 06 дугаар сарын 30-ны дотор УИХ-ын холбогдох байнгын хороонд хүргүүлсэн байх. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэхийн зэрэгцээ хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэлээ. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан 216 арга хэмжээний гүйцэтгэл 2020 онд 68.7 хувьтай байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 9.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2020” тайланг бэлтгэн хэвлүүлж, товхимол хэлбэрээр УИХ, Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүлэв. Энэхүү тайлан мэдээллийг УДШ, ШЕЗ-ийн дарга, Улсын ерөнхий прокурор, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, УИХ-ын дэргэдэх байгууллагуудын дарга, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, ЗГ-ын агентлагийн дарга, нийслэл, 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлж, байгууллагын цахим хуудсанд байршуулан, олон нийтэд хүргэлээ. | 1 дүгээр улиралд-АТҮХ-ийг хэрэгжүүлэгч байгууллагуудаас тайлан, мэдээг хүлээн авч, сан зохих журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байх;<br><br>2 дугаар улиралд: АТҮХ-ийн 2021 оны тайланг эмхэтгэн, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | I-II | |
| Гүйцэтгэлийн зорилт 1.10 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, арга зүйн удирдлагаар хангах, заавар, зөвлөгөө өгөх, хамтарч ажиллах-Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг харилцах байгууллагуудтай хамтран ажиллана. | | | | | | | |
| II. Авлигатай тэмцэх газрын стратеги төлөвлөгөө (2020-2023-)-нд тусгагдсан ажил, арга хэмжээ | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| С1 Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх ажиллагаа нь судалгаа, шинжилгээ, технологид тулгуурлан хэрэгжинэ. | | | | | | | |
| С1-1 Шийдвэр нь судалгаа, шинжилгээнд тулгуурладаг болно. | | | | | | | |
| 27. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.1.1 дүгээр арга хэмжээ-Байгууллагын өргөдөл, гомдлын менежментийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгохтой холбоотой үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх; /С1-1.1/ | США | -Өргөдөл, гомдлын менежментийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийгдэж танилцуулсан байх;<br>-Өргөдөл, гомдлын шилжүүлэлт, шийдвэрлэлтийн шат дамжлага боловсронгуй болсон байх;<br>-Иргэд, байгууллага, албан тушаалтан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үе шат, үр дүнгийн талаар тухай бүр мэдээлэл авах боломжоор бүрэн хангагдсан байх;<br>-Өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийг хугацаа богиносож, шийдвэрлэлтийн түвшин өссөн байх; | -Өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авах, хянах, удирдлагын шийдвэр гаргах, шийдвэрлэх үйл ажиллагааг нээлттэй, түргэн шуурхай болгох шаардлагатай;<br>-Хүлээн авсан нийт өргөдөл, гомдлын 31 хувийг харьяаллын бус өргөдөл гомдол эзэлж байна.<br>-Иргэдэд өргөдөл, гомдол, мэдээллийн хариуг хүлээн авах, танилцах арга замыг боловсронгуй болгох шаардлагатай байна.<br>-Өргөдөл, гомдол, мэдээллийн бүртгэлийн цахим систем 2020 оны 01 дүгээр сараас үйл ажиллагаанд нэвтэрсэн. | Эхний хагас жилд: -Өргөдөл, гомдлын менежментийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийгдэж танилцуулсан байх;<br>-Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, түүний дотор өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж байгаа этгээдээс хариуг хүлээн авах, танилцах арга хэлбэрийг боловсронгуй болгох ажил, арга хэмжээ тодорхой болж, ажлыг гүйцэтгэж эхэлсэн байх;<br>-Мэдээллийн санд тавих хяналт тодорхой болж, хугацаа сунгаж болон хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, мэдээллийн тоо буурсан байх;<br>Сүүлийн хагас жилд: -Технологид суурилсан арга шийдлүүдийг нэвтрүүлснээр иргэд өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн явцын талаар мэдээллийг хялбараар авах боломж бүрдсэн байх; -Дүн шинжилгээний үр дүн гарснаар байгууллагын өргөдөл, гомдлын менежмент боловсронгуй болсон байх; | I-IV | |
| 28. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.1.2 дугаар арга хэмжээ-Монголчуудын ёс заншил, уламжлал, ахуй соёлтой нийцсэн, зорилтот бүлэгт тохирсон соён гэгээрүүлэх үйл ажиллагааны арга, хэлбэрийг тодорхойлох судалгаа зохион байгуулах, судалгаанд холбогдох салбарын эрдэмтдийг татан оролцуулах; /Алсын хараа 2050-5.6.1, С1-1.2, С1-1.13, С2-2.1, С2-2.3/ | США<br>УССГХ | -Авлигын эсрэг соён гэгээрүүлэх арга хэмжээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал боловсруулах",<br>-"Монголчуудын ёс заншил, уламжлал, ахуй, соёлтой нийцсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны арга, хэлбэрийг тодорхойлох",<br>-"Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах соён гэгээрүүлэх үйл ажиллагааны стратеги (2022-2024) боловсруулах",<br>-Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй олон нийттэй харилцах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүн, ач холбогдлын талаарх олон нийтийн санаа бодлыг судалж, дүгнэлт, зөвлөмж санал боловсруулах (хяналт-шинжилгээ, | "Монголчуудын ёс заншил, уламжлал, ахуй соёлтой нийцсэн, зорилтот бүлэгт тохирсон соён гэгээрүүлэх үйл ажиллагааны арга, хэлбэрийг тодорхойлох судалгаа зохион байгуулах, судалгаанд холбогдох салбарын эрдэмтдийг татан оролцуулах; "Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх механизмыг бий болгох-Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны талаар олон нийтийн санал бодлыг судлан дүгнэлт гаргах, зөвлөмж санал боловсруулах, Төлөвлөгөөний дагуу арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцсон байх" "Авлигатай тэмцэх газраас олон нийттэй харилцах бодлогын баримт бичиг, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны стратеги боловсруулж, хэрэгжүүлэх" арга хэмжээнүүд нь агуулга, зорилго, дараалллын хувьд харилцан бие биетэйгээ хамааралтай, тус тусад нь хэрэгжүүлэх боломжгүй байх тул агуулгаар нь нэгтгэн "Авлигын эсрэг соён гэгээрүүлэх арга хэмжээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал боловсруулах", "Монголчуудын ёс заншил, уламжлал, ахуй, соёлтой нийцсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны арга, хэлбэрийг тодорхойлох", "Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах соён гэгээрүүлэх үйл ажиллагааны стратеги (2022-2024) боловсруулах", Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй олон нийттэй харилцах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүн, ач холбогдлын талаарх олон нийтийн санаа бодлыг судалж, дүгнэлт, зөвлөмж санал боловсруулах (хяналт-шинжилгээ, үнэлгээ | -Судалгааны үр дүнг хүлээн авч, авах арга хэмжээний санал тодорхой болсон байна.<br>-Үр дүнд чиглэгдсэн ажил арга хэмжээ төлөвлөгдөн хэрэгжсэн байна. | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үнэлгээ хийх)" ажил хийгдсэн байх;<br>-Судалгааны үр дүнд үндэслэн цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний санал танилцуулагдаж, холбогдох бусад арга хэмжээ авагдсан байх; | хийх)" гэсэн байдлаар судалгааг хийхээр өөрчилсөн. Тухайн судалгааны ажлыг гүйцэтгэхээр ШУА-ийн Философийн хүрээлэн, "Төрийн бодлогын шинжилгээний хүрээлэн" ТББ-ын судалгааны багууд шалгарсан тул зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулаад байна. Гүйцэтгэгчийн гэрээнд заасан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж хамтран ажиллаж байна. | | | |
| 29. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.1.3 дугаар арга хэмжээ-Авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тогтмол хөгжүүлэх, үйл ажиллагаанд ашиглах; /С1-1.3/ | США АБХШНА УССГХ ХШДШХ | -Програм хангамж хийх урьдач нөхцөлийг хангасан байх; | Нэгдсэн мэдээллийн сан байхгүй, хэлтэс, албад тус бүр чиг үүргийн мэдээллийг төвлөрүүлсэн боловч ихэвчлэн цаасан суурьтай байгаа тул мэдээллийн нэгдсэн байдал дутагдалтай байгаа. Байгууллагын 2007-2020 оны үйл ажиллагаанд хамаарах тоон мэдээллийг нэгтгэн боловсруулж, үйл ажиллагаанд ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн. | 1 дүгээр улиралд-Мэдээллийн нэгдсэн сан бий болгох хэрэгцээ шаардлагын алаар санал авч боловсруулалт хийж, санал танилцуулсан байна.<br>2 дугаар улиралд-Хэрэгцээ, шаардлагын дагуу холбогдох мэдээллийн сангийн бүтцийг бий болгох, программ хангамжийг хөгжүүлэх санал бэлтгэсэн байна. | I-II | |
| С1-2 Байгууллагын дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа хангагдсан байна. | | | | | | | |
| 30. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.1.4 дүгээр арга хэмжээ-Байгууллагын зохион байгуулалтын нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хууль, тогтоомжид заасны дагуу боловсруулж хэрэгжилтийг хангах; /С1-1.4/ | ТХ | Засгийн газраас батлагдсан загвар, шаардлагын дагуу хийгдэж баталгаажсан байх; | -Төрийн албаны тухай хууль, Засгийн газраас тогтоосон журмын дагуу 2021 онд гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан өөрчлөгдөж, шинэ агуулга, хэлбэрээр хийгдэх болсон.<br>-Төлөвлөгөө, тайланг зохих журмын дагуу хийж, хянал-шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөмж өгч хэвшсэн. | 1 дүгээр улиралд--Төлөвлөгөө, тайлан боловсруулах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгсөн байна.<br>-Байгууллагын жилийн, хэлтсийн хагас, бүтэн жилийн, албан хаагчдын 2022 оны төлөвлөгөө батлагдсан байна.<br>2, 4 дүгээр улиралд--Төлөвлөгөөний биелэлтийг шалгуур үзүүлэлт бүрээр, хагас, бүтэн жилээр тайлагнасан байна.<br>-Байгууллагын гүйцэтгэлийн тайланд хагас жилд хяналт шинжилгээ хийсэн байна.<br>Сүүлийн хагас жилд: Албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг улирал тутамд дүгнэсэн байна. Байгууллагын гүйцэтгэлийн тайланд жилийн эцэст хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Зөвлөмжөөр дэмжих ажиллагаа тогтмолжсон байна. | I-IV<br><br>II IV<br><br>III, IV | |
| 31. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.1.5 дугаар арга хэмжээ-Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн зөрчлийг илрүүлэх чиглэлээр байгууллагын бусад хэлтэс, албатай хамтран ажиллах; /С1-1.5/ | ХШДШХ | Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн зөрчлийн илрүүлэлтийн хувийг нэмэгдүүлэх /Нийт нарийвчлан шалгасан албан тушаалтнаас/; | 2021 онд Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн зөрчил шалгасан нийт хөрөнгө, орлогын мэдүүлгийн 3,4 хувийг эзэлж байна.. Төлөвлөгөөт хяналт шалгалтын хувьд "Барилгын хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын 13, "Эрчим хүчний хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын 14, "Зам тээврийн хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын 10, нийт 37, ТӨХК, ТӨХХК-ийн нийт мэдүүлэг гаргагчаас эрсдэл бүхий 35, бусад 28 мэдүүлэг гаргагчийн 2016-2020 оны ХАСХОМ-т хяналт шалгалт хийлээ. Мэдүүлэг гаргагчийн хөрөнгө орлого нь 1 тэрбум, түүнээс дээш хэмжээгээр өссөн болон давтамжтайгаар өсч байгаа 24 албан тушаалтны цэвэр хөрөнгийн байдалд харьцуулсан дүн шинжилгээ хийж, ийнхүү мэдүүлсэн мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн гишүүдийн татварын орлоготой нийцэж байгаа эсэхийг хянуулахаар Татварын ерөнхий газартай хамтран ажиллаж байна. Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 22 мэдүүлэг гаргагчийн үйлдлийг шалгуулахаар харьяалах хэлтэст шилжүүлсэн. | Эхний хагас жилд: нийт зөрчлийн 3,7 хувьд хүргэх. Энэ талаар Татварын ерөнхий газар болон ГАХ, МШХ-тэй хамтран ажиллах.<br><br>Сүүлийн хагас жилд: нийт зөрчлийн 3,9 хувьд хүргэх. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага, ТББ, Хэвлэлийн мэдээллийн байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, хамтран ажиллах. ГАХ, МШХ-тэй хамтран ажиллах. | I II<br><br>III IV | |
| С1-3 Байгууллага үйл ажиллагаандаа менежмент, технологийн шийдлийг нэвтрүүлж, ашигладаг болсон байна. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 32. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.1.6 дугаар арга хэмжээ-Авлигатай тэмцэх газраас олон нийттэй харилцах бодлогын баримт бичиг, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны стратеги боловсруулж, хэрэгжүүлэх; /С1-1.6/ | США<br>ТХ | -Бодлогын баримт бичиг боловсрогдож, баталгаажсан байх;<br>-Стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан байна.<br>Төлөвлөгөөний дагуу тодорхой ажил, арга хэмжээ хэрэгжсэн байна. | Авлигатай тэмцэх газраас олон нийттэй харилцах бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр Бизнес меридиан консалтинг ТББ-тай гэрээ байгуулаад судалгааны ажил хийгдэж байна.<br>АТГ-ын соён гэгээрүүлэх үйл ажиллагааны стратеги боловсруулах" буюу стратеги төлөвлөгөөний С1-2-т заасан ажил, арга хэмжээг энэхүү төлөвлөгөөний 1.11.1.2-т заасанаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно. | 1 дүгээр улиралд-Бодлогын баримт бичиг батлагдсан байх;<br>2-4 дүгээр улиралд-Сүүлийн хагас жилд: Стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан байна.<br>Төлөвлөгөөний дагуу тодорхой ажил, арга хэмжээ хэрэгжсэн байна. | I-IV | |
| 33. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.1.7 дугаар арга хэмжээ-Иргэдтэй харилцах аппликэйшнийг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлах; /С1-1.7/ | УССГХ | -Аппликэйшнийг 10000-аас доошгүй иргэнд сурталчилсан байх;<br><br>-Аппликэйшнд шаардлагатай мэдээ, мэдээллийг оруулж, үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн байх; | Иргэдтэй харилцах 110 мэдээллийн аппликэйшнийг Глобал вишн ХХК-аар гүйцэтгүүлж, хөгжүүлэх, хүлээн авах ажлыг зохион байгуулав. Аппликэйшний хүлээж авах ажлын хүрээнд нийт 152 мэдээ мэдээлэл оруулж туршилт хийсэн бөгөөд нийт хандалт 5724 болоод байна. 2021 оны 3 дугаар улиралд олон нийтэд сурталчилж таталт хийлгэхэд бэлэн болсон байна. Аппликэйшнээр дамжуулан иргэдээс санал асуулга авах боломжтой болсон бөгөөд одоогийн байдлаар 6 санал асуулга туршилтын журмаар оруулсан байна. | Аппликэйшнд шаардлагатай мэдээ, мэдээллийг оруулж, үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн байх; | I-IV | |
| 34. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.1.7 дугаар арга хэмжээ-Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд шаардагдах, мэдээлэл, харилцаа, холбооны технологийг судалж нэвтрүүлэх; /С1-7/ | АБХШНА<br>УССГХ | Цахим сургалтын плаформыг хөгжүүлсэн байна. | * | -Платформын хөгжүүлэлт хийгдсэн байх;<br>-Сургалтын контентуудыг бүтээх, баяжуулалт хийх ажлыг зохион байгуулсан байх;<br>-Цахим платформыг ажиллагаанд оруулж, иргэн, хувийн хэвшил, төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг сургалтад хамруулсан байх; | I-II | |
| 35. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.1.8 дугаар арга хэмжээ-Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн зохицуулалтад иж бүрэн шинжилгээ хийж, өөрчлөлт хийх бэлтгэл ажлыг хангах; /С1-8/ | ТХ<br>бусад хэлтэс, албад | -Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн зохицуулалтад иж бүрэн шинжилгээ хийж, өөрчлөлт хийх бэлтгэл ажлыг хангасан байна. | * | -Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн зохицуулалтад иж бүрэн шинжилгээ хийх ажлын даалгавар бэлэн болж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.<br>-Ажлын үр дүнг хүлээн авсан байна.<br>-Үр дүнд үндэслэн холбогдох санал боловсруулагдаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн байх. | I-IV | |
| 36. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.1.9 дүгээр арга хэмжээ-Хяналт шалгалтын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгах хувь хэмжээг нэмэгдүүлэх; /С1-9/ | ХШДШХ<br><br>АБХШНА | -Хайлтын системийн мэдээллийн санг бүрэн ашигладаг болгох, программын хөгжүүлэлт хийх;<br>-Шалгасан хөрөнгө орлогын мэдүүлгийн хувь хэмжээ нэмэгдсэн байх; | Хайлт лавлагааны нэгдсэн систем (search.iaac.mn)-ийг хөгжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэд байна. Үүнд: Үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хуулийн этгээдийн мэдээллийн сервисүүдийг эксченж системээс "Хур" системд бүрэн шилжүүлэх програмчлалын ажлыг хийж дуусган 2021 оны 03 сарын 02-ны өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлснээр хуулийн этгээдэд хамаарах нэмэлт мэдээллүүдийг авч, үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдэв. Мөрдөн шалгах болон хяналт шалгалтын ажиллагаанд төрийн бусад байгууллагын мэдээллийг ашиглах үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор Татварын ерөнхий газартай | Эхний хагас жилд:; Бусад байгууллагуудын санд онлайн холбогдсоноор шаардлагатай мэдээллийг бүрэн авах боломжийг судалсан байх;<br><br>Сүүлийн хагас жилд: Мэдээлэл, лавлагаа авах боломжтой байгууллагуудтай хамтарч ажиллах, харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байх.. | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | “Мэдээлэл харилцан солилцох” гэрээ байгуулж, мэдээллийн санг холбож, үйл ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүлэв. 2021 оны эцсээр хайлт лавлагааны нэгдсэн системийг ашиглалтад оруулснаар улсын бүртгэлийн байгууллагуудын санд онлайн холбогдож, шаардлагатай мэдээллийн 80 хувийг олж чадаж байна. | | | |
| 37. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.1.10 дугаар арга хэмжээ-Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянах үйл ажиллагааг бүрэн цахимжуулах, төрийн байгууллагуудын бүртгэл, мэдээллийн цахим санг бүрэн холбож ашиглах боломжийг нэмэгдүүлэх; /СТШҮ-1.10/ | ХШДШХ АБХШНА | -ХАСУМ-ийн хяналтыг бүрэн цахимжуулсан байх;<br>-Үйл ажиллагаанд шаардлагатай байгаа төрийн байгууллагуудын бүртгэл, мэдээллийн цахим санг бүрэн холбож ашиглах боломжийг нэмэгдүүлэх; | ХАСУМ-ийг цахимаар мэдүүлэх талаарх саналыг авч, програмд хөгжүүлэлтийг хийснээр нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим системээр хүлээн авч хянах ажлын хүрээнд нийт холбовол зохих нэгжийн 90.0 хувийг холбосноор үйл ажиллагаа хөнгөвчлөгдөх нөхцөл бүрдлээ. 2021 онд хүлээн авсан нийт ХАСУМ-ийн 84,0 хувийг цахим хэлбэрээр хүлээн авч, хянан шийдвэрлэсэн бол 2020 онд нийт хүлээн авсан ХАСУМ-ийн 75,9 хувийг цахим хэлбэрээр хүлээн авч хянасан байгаагаас үзэхэд ХАСУМ-ийг цахим хэлбэрээр хүлээн авч хянасан үзүүлэлт өмнөх онтой харьцуулбал 8,1 пунктээр өссөн байна. | Эхний хагас жилд: -Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим бусаар ирүүлдэг төрийн тусгай байгууллагуудыг цахимаар хянадаг болох боломжийг судалж, хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байх,<br>Сүүлийн хагас жилд: -Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим хэлбэрээр хүлээн авч, хянах үйл ажиллагааны чанар, үр дүнг дээшлүүлсэн байх; | I-IV | |
| С2 Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа олон нийтийн оролцоонд түшиглэдэг болно. | | | | | | | |
| 38. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.2.1 дүгээр арга хэмжээ-Авлигаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг таниулах, авлигыг үл тэвчих нийгмийн сэтгэл үйг төлөвшүүлэхэд чиглэсэн үндэсний контент бэлтгэн олон нийтэд хүргэх; /С2-2.2/ | УССГХ | -Соён гэгээрүүлэх аянд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн зэрэг 5 хүртэлх салбарын 30-аас доошгүй төлөөллийг оролцуулсан контент хийсэн байх;<br>-“Шударга ёс, хөгжил дэвшилд #110” подкастыг төлөвлөгөөний дагуу 10-аас доошгүй дугаар бэлтгэн, түгээсэн байх;<br>-Радиотой хамтран контент, шторк, зохиомж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг зэргийг бэлтгэн хүргэсэн байх;<br>-Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны талаар нэвтрүүлэг бэлтгэн түгээсэн байх; | -2020 оны 12 дугаар сард “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяныг зохион байгуулсан.<br>-2020, 2021 онд подкастын сувгийг үүсэж, тохиромжтой платформуудад байршуулж, хөгжүүлэлтийг хийсэн.<br>-МҮОНР, Дэлхийн монголчууд 88,3, Гэр бүлийн радио 104,5 зэрэг радиогоор олон талт мэдээллийг хүргэсэн. 2021 онд 23 дугаар бэлтгэн олон нийтэд хүргэсэн. | Жилдээ-Авлигаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг таниулах, авлигыг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд энгийн ойлгомжтой хэлбэрээр танилцуулахад чиглэсэн богино хэмжээний контентуудыг бүтээж, олон нийтэд хүргэсэн байх;<br>-“Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяныг үргэлжлүүлэн зохион байгуулна.<br>-Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр подкастын 10 шинэ дугаарыг бэлтгэн олон нийтэд хүргэсэн байна.<br>-Богино долгионы FM, МҮОНР-оор соён гэгээрүүлэх контент, зохиомж зэргийг бэлтгэн хүргэх, сурталчлах, сан үүсгэсэн байна.<br>-”АТГ-ын цаг” 14 хоног тутмын нэвтрүүлгийг бэлтгэн түгээж, сан үүсгэсэн байна.<br>4 дүгээр улирал-Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан арга хэмжээ зохион байгуулсан байна. | I-IV<br>IV | |
| 39. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.2.2 дугаар дугаар арга хэмжээ- Авлигын гэмт хэрэг, зөрчлийг мэдээлэх, илрүүлэх, мөрдөн шалгах, шийдвэрлэхтэй холбоотой бодит жишээ, баримтад тулгуурлан соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах; /С2-2.5/ | УССГХ, МШХ, ХШДШХ | Мэдээлэл солилцсон байх, бодит баримт мэдээлэл, шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг жишээ болгон сонгон авч соён гэгээрүүлэх ажил зохион байгуулсан байх; | 2021 онд эрх бүхий албан тушаалтанд мөрдөгчийн 162 мэдэгдэл бичиж, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хууль хэрэгжүүлэх, зөрчил арилгуулах, авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авхуулахаар 61 албан бичгийг хүргүүлсэн. Бичсэн мэдэгдлийн тоо өмнөх оноос 59-өөр буюу 57.2 хувиар, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хууль хэрэгжүүлэх, зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн тоо 18 буюу 41.8 хувиар тус тус өссөн. Мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичиг болон хариуг тухай бүр УССГХ-т хүргүүлж ажилласан. | -Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн мөрдөгчийн мэдэгдэл зөрчил арилгуулах албан бичгийн талаархи мэдээллийн цаг тухайд нь УССГХ-т хүргүүлсэн байх;<br>-Бодит баримт мэдээлэл, шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг жишээ болгон сонгон авч соён гэгээрүүлэх ажил зохион байгуулсан байх; | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| С2-2 Иргэд, иргэний нийгмийн болон хувийн хэвшлээс гаргасан авлигын эсрэг үйл ажиллагаа, санаачилгыг дэмждэг болсон байна. | | | | | | | |
| 40. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.2.3 дугаар арга хэмжээ-Авлигаас урьдчилан сэргийлэх, үр дүнтэй бодлого, тогтолцоог санаачилж хэрэгжүүлсэн байгууллагыг урамшуулах механизм бүрдүүлэх; энэ чиглэлээр үр дүнтэй ажилласан иргэд, байгууллагыг сурталчлах; /С2-2.6; СТШҮ-2.6/ | УССГХ | -Судалгаа, шинжилгээ хийж, санал /эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалт/-ыг шийдвэрлүүлсэн байх;<br>-Дэмжих, урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлж жил бүрийн төсөвт тусгасан байх;<br>-Дэмжиж, урамшуулах, сурталчлах ажлыг зохион байгуулж хэвшсэн байх; | Авлигын эсрэг үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, байгууллагад олон улсын байгууллагаас олгодог шагналын талаар судалгаа хийж, төрийн бус байгууллагуудад зориулсан шагнал бий болгох шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулан танилцуулсан. | 1 дүгээр улиралд-Авлигатай тэмцэх чиглэлээр санаачилга гарган р дүнтэй ажилласан иргэн, байгууллагыг дэмжиж, урамшуулах, сурталчлах эрх зүйн зохицуулалтыг бий болгосон байх;<br><br>Жилдээ-Дэмжиж урамшуулах, сурталчлах ажлыг зохион байгуулж, хэвшсэн байх; | I<br><br><br><br>I-IV | |
| 41. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.2.4 дүгээр арга хэмжээ- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын идэвхтэй оролцоонд тулгуурласан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах; /С2-2.7/ | УССГХ | -Орон нутагт авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зохион байгуулсан байх; | 2021 онд Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилт, явц байдал болон мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээтэй танилцах, шалган туслах, аймгийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлттэй танилцах, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор орон нутагт зайнаас ажилласан. Энэ хүрээнд 21 аймгийн худалдан авах ажиллагаа, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах үйл ажиллагаа, сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн санд холбогдох үйл ажиллагаа, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас баталсан шийдвэр, дүрэм, журамд дүн шинжилгээ хийж, тайлан боловсруулж байна. | -Орон нутагт авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зохион байгуулсан байх;<br>-Үр дүнг нэгтгэн санал танилцуулсан байх;<br>-Зөвлөмж, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн байх; | I-IV | |
| 42. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.2.5 дугаар арга хэмжээ-Хөрөнгө, орлогын мэдүүлгийг олон нийтэд мэдээлэхдээ дэлгэрэнгүй, ойлгомжтой хэлбэрээр нийтэд нээлттэй болгож, олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг бүрдүүлэх; /С2-2.7/ | ХШДШХ | -Олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх;<br>-Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим сүлжээнд тавьж олон нийтийг мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн байх; | Цахим системд мэдүүлгээ гаргаж бүртгүүлсэн төрийн болон нутгийн захиргааны нийт 43692 албан тушаалтны 2020 оны ХОМ-ийн хураангуйг 2020.06.30-ны өдөр тус газрын http://www.xacxom.iaac.mn цахим хуудсанд нээлттэй байршуулж, олон нийтийг мэдээллээр хангаж ажиллалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явагдсан Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тус газрын https://meduuleg.iaac.mn/ цахим системд бүртгэх, хүлээн авч, ХОМ-ийн хураангуйг http://xacxom.iaac.mn/ цахим сүлжээнд байршуулж, олон нийтийг мэдээллээр хангасан болно. | Мэдээллийг цахим сүлжээнд иргэдэд ойлгомжтой хялбаршуулсан байдлаар байршуулж мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн байх;. | I,II | |
| 43. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.2.6 дугаар арга хэмжээ- Авлига, бусад гэмт хэрэг, зөрчлийн чиглэлээр дагнан ажилладаг болон эрэн сурвалжлах сэтгүүлчидтэй хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох, зөвлөлдөх; /С2-2.8/ | УССГХ<br>ХШДШХ | -Сэтгүүлчид сургалт зохион байгуулсан, зөвлөгөөн зохион байгуулсан байх;<br>-Эрэн сурвалжлах сэтгүүлчдээс ирэх мэдээллийн хувь өссөн байх; | * | -Сэтгүүлчидтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.<br>-Сэтгүүлчдэд зөвлөмж, арга зүйн зөвлөгөө өгсөн байна.<br>-Эрэн сурвалжлах сэтгүүлчдээс ирэх мэдээллийн хувь өссөн байх; | II<br><br><br><br><br>I-IV | |
| С3. Зорилтот бүлгийн онцлогт тохируулан соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулдаг болсон байна. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 44. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.2.7 дугаар арга хэмжээ-Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн агуулгыг тусгах; /Алсын хараа 2050-5.6.1, С2-2.11/ | УССГХ | -Сургалт хөтөлбөрт тусгах агуулгыг тодорхойлж, сурагчдын нас, сэтгэхүйд тохирсон гарын авлага, хэрэглэгдэхүүн боловсруулсан байх; | “Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хичээл, сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хүүхэд, залууст шударга ёсны хандлагыг төлөвшүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлгийг 2021 оны 3 дугаар сарын 5-ны өдөр зохион байгууллаа. “Ерөнхий боловсролын болон дээд боловсролын сургалтын хөтөлбөрт шударга ёсны хандлага, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга туссан байдалд хийсэн дүн шинжилгээ”-тэй танилцаж, ерөнхий боловсролын ба их, дээд сургуулийн гэсэн 2 салбар хуралдаанаар илтгэл хэлэлцүүлэв. Тус хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн боловсролын салбарын бодлого, тогтолцоо, хүний нөөц, ЕБС, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд авлигаас ангид байх зан үйлийг дадал хэвшил болгох хөтөлбөр, санаачилгыг дэмжих, шударга бус байдал шударга байдлын үнэлэмжийн нэгдмэл ойлголтыг бий болгох чиглэлээр эрдэмтэн, судлаачид, боловсролын байгууллагуудын хамтран ажиллах санаачилгыг өрнүүлэх, оюутны сайн дурын арга хэмжээг авлигын эсрэг чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шударга ёсны талаарх агуулгыг заавал судлах шаардлагатай мэргэжлүүдийг тодорхойлох, хичээлийн ойлголт, заах арга, хэрэглэгдэхүүнийг бий болгох, энэ чиглэлээр багш бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх, элсэлтийн ерөнхий шалгалтын агуулгад шударга ёсны сэдвийг тусгах, авлигыг үл тэвчих, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх мэдлэг, чадварыг илрүүлэх даалгавар бий болгох зэрэг асуудлыг хөндөн тусгаж, Ерөнхий сайдад хүргүүлсэн. Бага ангийн сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон гарын авлагыг боловсруулах, эмхэтгэх ажил хийгдэж байна. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зөв дадлыг төлөвшүүлж, авлигын эсрэг боловсрол мэдлэг олгох “Зөв зөвд шударга зөв” гарын авлагыг хэвлүүлж, олон нийтэд түгээсэн. | -ЕБС-ийн Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт агуулга тусгуулах асуудлаар хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр ажиллах, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж ажилласан байх;<br><br>-Боловсролын бусад байгууллагын агуулгад зохих дүн шинжилгээг хийж, сургалтын агуулга, хөтөлбөр авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шударга ёсны ойлголт мэдлэгийг дээшлүүлэх агуулга, сэдэв тусгуулахад чиглэсэн арга хэмжээ авах, хамтран ажиллаж, үр дүнг тооцсон байх; | I-IV | |
| С3: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлага нэвтэрсэн байна. | | | | | | | |
| 1. Эрсдлийн үнэлгээ хийдэг болсон байна. | | | | | | | |
| 45. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.3.1 дүгээр арга хэмжээ-Хяналт шалгалтын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх арга зүй, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх; / Алсын хараа 2050-5.6.8, С3-3.2, С3-3.4/ | ХШДШХ | Хяналт шалгалтын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх арга зүй, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх; | Тайлант хугацаанд мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт, дүн шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, нэгдсэн арга зүйг нэвтрүүлэх зорилгоор Дэлхийн банкны “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хяналт шалгалтыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга (СтАР)-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсад зөвлөх үйлчилгээ үзүүлсэн Дэлхийн банкны шинжээч Кристофор Албериногийн ирүүлсэн зөвлөмжийн дагуу “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт эрсдэл тооцох аргачлал”-ыг боловсруулан цахим системээр дамжуулан мэдүүлгээ шинэчлэн гаргасан 40 гаруй мянган албан тушаалтны мэдүүлэгт 30 орчим үзүүлэлтээр эрсдэл тооцов. Тухайлбал, 2019-2020 онд мэдүүлэг гаргасан 38.9 мянган албан тушаалтны мэдээлэлд эрсдэл тооцоход 8292 албан тушаалтан эрсдэлтэй гэсэн тооцоо гарсан. Иймд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | Эхний хагас жилд: Албан тушаалтнуудын мэдүүлэгт үндэслэн эрсдэл тооцсон байна.<br><br>Сүүлийн хагас жилд: Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан эрсдэл бүхий салбар нэгжид арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;<br><br>-Өргөдөл, гомдол, мэдээллийн дүн шинжилгээнд үндэслэн салбар байгууллага, орон нутагт хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулсан байна. | I-IV | |
| 2. Эрсдэлийн түвшнээс хамааран урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулдаг болно. | | | | | | | |
| 46. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.3.2 дугаар арга хэмжээ-Эрсдэлийн | УССГХ | -Тухайн салбарт ажиллах үйл ажиллагааг | Шударга байдлын 2021 оны үнэлгээгээр яамдаас Байгаль, орчин аялал жуулчлалын яам 66.1, Эрүүл мэндийн яам 68.2 оноотой, агентлагаас Улсын бүртгэлийн ерөнхий газар | -Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрүүл мэндийн яам, Батлан хамгаалах яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд ажиллах; | I-II | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | түвшнээс хамааруулан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг ялгавартай тогтоож, багц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; | | тодорхойлсон удирдамж батлагдсан байх;<br>-Ажлын үр дүнг нэгтгэж, цаашид авах арга хэмжээний саналын хамт танилцуулсан байх;<br>-Сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан байх; | 67.3, Ашигт малтмал, газрын тосны газар 67.7, Мал, эмнэлгийн ерөнхий газар 67.8, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 67.9 оноотой, аймгуудаас Хөвсгөл аймгийн ЗДТГ 59.0, Баян-Өлгий аймгийн ЗДТГ 61.8, Ховд аймгийн ЗДТГ 67.3 оноотой тус тус хамгийн бага үнэлгээ авсан байна. | -Хөвсгөл, Баян-Өлгий, Ховд, Архангай, Дорноговь аймагт ажиллах;<br><br>-Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Мал эмнэлгийн ерөнхий газар,<br>Гаалийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газарт ажиллах; | I-II<br><br>I | |
| 3. Хөрөнгө орлого, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн бүртгэл, хяналт, дүн шинжилгээний иж бүрэн цахим систем нэвтэрсэн байна. | | | | | | | |
| 47. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.3.3 дугаар арга хэмжээ-Хөрөнгө орлого, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хянах, дүн шинжилгээ хийх, мэдээлэх үйл ажиллагааны цахим системд шинжилгээ хийж, боловсронгуй болгох ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх; | ХШДШХ | ХАСХОМ-ийн цахим систем боловсронгуй болсон байна | Цахим системийг боловсронгуй болгох ажлын хүрээнд системийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөх үйлчилгээ авч ажиллав. Улмаар цахим системийн програм хангамж, тоног төхөөрөмжийг хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулав.Цахим системийг боловсронгуй болгоход шаардлагатай төсвийг шийдвэрлүүлэх зорилгоор ЗГХЭГ, Дэлхийн банкинд хандан, цуврал уулзалт зохион байгуулан ажиллав. Улмаар Дэлхийн банкнаас төслийг санхүүжүүлэх шийдвэр гаргасныг Сангийн сайд албажуулав. Тус газарт ашиглаж буй цахим системийг цогц байдлаар хөгжүүлэх, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын сонгон шалгаруулалт, худалдан авалтын төлөвлөгөөг Дэлхийн банкны “Ухаалаг засаг” төслийн удирдах хороонд танилцуулж батлуулсан бөгөөд төлөвлөгөөний дагуу холбогдох бэлтгэл ажлыг хангаад байна. | Эхний хагас жилд: Дэлхийн банк, ЗГХЭГ-ын төслийн нэгжтэй хамтран худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу холбогдох зөвлөхийг сонгон шалгаруулах, тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг зохион байгуулах;<br>Сонгон шалгарсан зөвлөхтэй нягт хамтран ажиллах, системийг боловсруулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах.<br><br>Сүүлийн хагас жилд: Цахим системийн холбогдох хэсгийг зөвлөхөөс хүлээн авч, туршсан байх. | I-IV | |
| С4 Гүйцэтгэлийн зорилт №1.11.4 Авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажил нь хамтын ажиллагаанд тулгуурладаг болно. | | | | | | | |
| 2. Авлигын гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийн хувь нэмэгдсэн байна. | | | | | | | |
| 48. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.4.1 дүгээр арга хэмжээ-Санхүүгийн мөрдөгчийн албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдыг сургалтад хамруулж мэргэшүүлэх;<br>/Алсын хараа 2050-5.6.4/ | ТХ<br>МШХ | -Албан хаагчдыг системтэйгээр сургалтад хамруулж, мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг нэмэгдүүлсэн байх;<br>-Сургалт зохих журмын дагуу зохион байгуулагдсан байх; | 2019 онд санхүүгийн мөрдөгчийн орон тоог бий болгосон. Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, Европын гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилгатай хамтран “Иргэний нэхэмжлэлээр олон улсад хөрөнгө хураах ажиллагаа” сэдэвт цахим сургалтад ГАХ, МШХ-ийн 65, “Криптовалют ба түүний онцлог”, “Удиртгал хичээл-Даркнеб” богино хугацааны вебинар буюу цахим семинарт АТГ, ЦЕГ, УЕПГ-ын 400, “Санхүүгийн мөрдлөг” сургалтад АТГ, ЦЕГ, УЕПГ-ын 24 албан хаагчийг хамруулав. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн европ, төв азийн авлигын эсрэг сүлжээ, Ази номхон далайн орнуудын авлигын эсрэг сүлжээ, ОХУ-ын Засгийн газрын дэргэдэх Санхүүгийн их сургууль, Авлигын эсрэг олон улсын академи, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хороо, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба зэрэг гадаад улсын болон олон улсын байгууллагаас зохион байгуулсан авлигаас урьдчилан сэргийлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэг мөрдөн шалгах чиглэлийн сургалтуудад, давхардсан тоогоор байгууллагын 120 гаруй албан хаагчийг хамруулав. | -Албан хаагчдыг системтэйгээр сургалтад хамруулж, мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг нэмэгдүүлсэн байх;<br>-Сургалт зохих журмын дагуу зохион байгуулагдсан байх; | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 49. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.4.2 дугаар арга хэмжээ-Гэрч хохирогч, мэдээлэгчийг хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалтыг хийж, холбогдох эрхийн актуудад тусган баталгаажуулах; | ТХ<br>ГАХ<br>МШХ<br>АБХШНА | -Гэрч хохирогч, мэдээлэгчийг хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалтыг хийж, холбогдох эрхийн актуудад тусган баталгаажуулах; | Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.12-т “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;” үйл ажиллагаа нь АТГ-ын бүрэн эрхэд хамаарахаар заасан. Иймд үйл ажиллагааны болон эрх зүйн зохицуулалтын хүрээнд эрхийн актуудад тусган, албан хаагчдыг үүрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байгаа. | -Гэрч хохирогч, мэдээлэгчийг хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалтыг хийж, холбогдох эрхийн актуудад тусган баталгаажуулсан байх; | I-II | |
| С5 Гүйцэтгэлийн зорилт №1.11.5 Мэдлэг чадвартай хүний нөөц, мэргэшсэн албан хаагчдад тулгуурлан байгууллагын чадавхи бэхжинэ. | | | | | | | |
| 1. Ажил үүргээ мэргэжлийн түвшинд, үр дүнтэй гүйцэтгэх мэдлэг чадвар бүхий мэргэшсэн албан хаагчидтай байна. | | | | | | | |
| 50. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.5.1 дүгээр арга хэмжээ--Хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах; | ТХ | -2022 онд зохион байгуулагдах Хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажил зохион байгуулагдсан байх; | -Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах журам”-д нийцүүлэн хүний нөөцийн бодлогын баримт бичиг боловсруулсан. | Эхний хагас жилд:<br>-Сургалтын төлөвлөгөө, төсөв батлагдсан байна. Сурталчлах ажил зохион байгуулагдсан байна.<br>Сүүлийн хагас жилд: Төлөвлөгөөний 2022 оны хэрэгжилт хангагдсан байна. | I-IV | |
| 2. Байгууллагын соёл, үнэт зүйлсийн нэгдмэл байдлыг хангасан удирдлагын манлайллыг хэрэгжүүлдэг болно. | | | | | | | |
| 51. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.5.2 дугаар арга хэмжээ-Байгууллагын соёлын нөхцөл байдлын судалгаа хийж, үйл ажиллагаандаа ашиглах; | ТХ<br>США | -Байгууллагын соёлын нөхцөл байдлын судалгаа хийж, үйл ажиллагаандаа ашиглах нөхцөл бүрдсэн байх; | - | -Судалгааг зохион байгуулж үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээ авсан байна. | I-III | |
| 52. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.5.3 дугаар арга хэмжээ-Хуулийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх; | ТХ<br>США | -Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны стратеги батлагдаж, мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх төлөвлөгөө батлагдаж мөрдөгдсөн байна.<br>-Албан хаагчдыг чадавхижуулсан байна.<br>-Холбогдох мэдээллүүдийг бэлтгэн Олон улсын байгууллага, Дипломат төлөөлөгчдийн газарт тогтмол хүргүүлж хэвшсэн байх; | 2021 онд байгууллагаас баримталж байгаа бодлогын хүрээнд Тамгын хэлтэст Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ахлах ажилтны 1, ажилтны 1 орон тоог бий болгож, бусад хэлтэст ажиллаж байгаа албан хаагчдаас дээрх орон тоог нөхөх арга хэмжээг авсан. Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийн түгээлтийг сайжруулах, ялангуяа гадаад улс, Монгол улсад суугаа элчин сайдын яамд, олон улсын байгууллага, гадаад улсын мэдээллийн агентлагуудад мэдээ, мэдээлэл түгээхэд анхаарч ажиллав. “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2020"-г англи хэл дээр орчуулан бэлтгэж, гадаад улсын хамтын ажиллагаатай байгууллага, олон улсын байгууллага, Транспаренси Интернейшнл байгууллагын Авлигын төсөөллийн индексийн эх сурвалж болдог болон бусад олон улсын судалгааны байгууллагууд, Монгол Улс дахь элчин сайдын яамд, судалгааны байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын хөгжлийн түнш, бизнесийн зөвлөлүүдэд зэрэг 300 гаруй байгууллага, хувь хүнд хүргүүлэв. Байгууллагын үйл ажиллагааны талаар танилцуулж, сурталчлах зорилгоор сар бүр Мэдээллийн хуудас хүргүүлж байна. Түүнчлэн Ази, номхон далайн орнуудын шударга байдлын үйл ажиллагааны “AP-Intact” сүлжээ (https://newsbin-apintact.blogspot.com/), “ConventusLaw” (https://www.conventuslaw.com/) олон | Жилдээ-Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны стратегийн дагуу мэдээллийн урсгал нэмэгдэж, байгууллагын ил тод, нээлттэй байдал хангагдсан байна. | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | улсын хуулийн фирмийн мэдээллийн хуудсанд байршуулахаар холбогдох мэдээллүүдийг тухай бүр, тогтмол илгээж байна. Байгууллагын цахим хуудсыг шинэчилснээр англи, монгол хэлээр мэдээлэл авах боломжийг бүрдүүлэв. Энэ хүрээнд байгууллагын 2020 оны үйл ажиллагаанд хамаарах мэдээ, мэдээллийг англи хэлээр байршуулж, 2021 оноос 7 хоног тутмын онцлох үйл ажиллагааны талаарх мэдээллийг орчуулан тогтмол байршуулж хэвшлээ. | | | |
| Хоёрдугаар хэсэг. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ / хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг /<br>Гүйцэтгэлийн зорилт №2.1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| Гүйцэтгэлийн зорилт № 2.1.1. Авлигын эсрэг хуульд заасан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулах зохицуулах, арга зүйн удирдлагаар хангах. | | | | | | | |
| 53. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.1 дүгээр арга хэмжээ-Авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, иргэний санал, санаачилгыг дэмжин туслах, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах; /АЭХ 18.1.4/ | УССГХ | -Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний 30% нь иргэд, олон нийт, ТББ-ын оролцоонд тулгуурласан байх. | -Авлигаас урьдчилан сэргийлэх талаар санал, санаачилгыг дэмжин, оролцоог нэмэгдүүлж ажиллаж чиглэлээр нийт 26 ТББ, 11 иргэн, 1 төрийн өмчит судалгааны байгууллага, 87 компанитай гэрээ байгуулж, ажилласан байна. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн болон Авлигатай тэмцэх газрын стратегийн зорилтуудын хүрээнд хамаарах чиглэлээр авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний санал, санаачилга гаргасан төр, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог хангах, боломжтой дэмжлэгийг үзүүлсэн байх; | I-IV | |
| 54. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.2 дугаар арга хэмжээ-Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, авлигад өртөх боломжийг багасгах талаар Зөвлөмж хүргүүлэх; /АЭХ 18.1.6/ | УССГХ | -Хүнд суртал, чирэгдлийг арилгахад чиглэсэн байх;<br>-Ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэсэн байх;<br>-Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх. | “Их, дээд болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр дамжуулан шударга ёсны хандлагыг төлөвшүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг Монгол улсын Ерөнхий сайдад, Дорнод аймгийн албан ёсны цахим хуудсанд хийсэн үнэлгээнд үндэслэн тус аймгийн Засаг даргын Тамгын газарт, БОАЖЯ, Богдхан уулын дархан цаазат хамгаалалтын газарт ажилласан дүнд үндэслэн тус газрын хамгаалалтын захиргаанд, Олон улсын ачаа тээврийн “С” зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЗТХ-ийн сайдад, Нийслэлийн Өргөө амаржих газар, Дорнод аймаг, Чойбалсан сумын ИТХ-ын дарга, ЦЕГ-ын даргад мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр, Эрүүл мэндийн сайдад төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалттай холбоотой нөхцөл байдлыг тодорхой болгох чиглэлээр, ХХААХҮ-ийн сайдад “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын хэрэгжилттэй холбоотой зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. | Жилдээ: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, ил тод, нээлттэй байдлыг хангуулахад чиглэсэн 10-аас доошгүй Зөвлөмж хүргүүлсэн байх;<br><br>-2021 онд хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлтийг тооцсон байх;<br><br>“Авлигын эсрэг үндэсний чуулган-2021”-т оролцогчдоос гаргасан зөвлөмжийн мөрөөр ажиллаж үр дүнг тооцсон байх; | I-IV<br><br>I-IV<br><br>I-II | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 55. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.3 дугаар арга хэмжээ-Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах, ёс зүйн дүрмийн төсөлд санал өгөх; /Алсын хараа 2050-5.6.7 АЭХ 18.4.2/ | УССГХ | -АТГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/183 дугаар тушаалаар баталсан "Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар"-ын шаардлага хангасан байх;<br>-act.iaac.mn цахим бүртгэлийн системд бүртгэлийг оруулсан байна. | 2020 онд 18, 2021 онд Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Гаалийн ерөнхий газар, Хавдар судлалын үндэсний төв, Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал, Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Онцгой комиссоос батлан гаргасан нийт 18 дүрэм, журам, шийдвэрийг хянаж, өөрчлөх, хүчингүй болгуулах талаар санал, зөвлөмж хүргүүлсэн, 2 шийдвэрийг хүчингүй болгуулав.<br>Төрийн байгууллага, салбарын хэмжээнд мөрдөх 13 ёс зүйн дүрмийн төсөл, зарим хуулийн этгээдийн Ёс зүйн зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайланг судалж, санал боловсруулж хүргүүлсэн | Жилдээ-Салбар тус бүрт 2, нийт 30-аас доошгүй дүрэм, журам хянаж, үр дүнг танилцуулж, санал хүргүүлсэн байх;<br><br>-Хянасан дүрэм журмыг цахим системд бүрэн оруулсан байх;<br><br>-Дүрэм журам бүртгэх системийг боловсронгуй болгосон байх;<br><br>-АТГ-аас хүргүүлсэн саналыг тусгасан эсэхэд хяналт тавьж, бүртгэл хөтөлсөн байх; | I-IV | |
| 56. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.4 дүгээр арга хэмжээ-Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журмыг хэрэгжилтийг хангах, сан хөтлөх; /НАНбХАСЗАСЗУСтХ 29.5/ | УССГХ | АТГ-ын даргын 2018 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан "Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийн холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ын шаардлагыг хангасан байх; | Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаар холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ын 2019-2021 оны эхний хагас жилийн байдлаар дүн шинжилгээ хийж, журмын хэрэгжилтийг сайжруулах, нэг мөр хангуулахад чиглэсэн саналыг эцэслэн боловсруулж, танилцуулав. 2021 оны эхний хагас жилийн байдлаар авлигын эсрэг хууль тогтоомжид заасан үндэслэлээр хариуцлага тооцогдсон 2 албан тушаалтны мэдээллийг "байгууллагын албан ёсны цахим хуудас дахь "Сахилгын шийтгэл" цэсэд байршуулсан. | Жилдээ-Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаар холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ын дагуу сан хөтөлсөн байх;<br><br>-Тайлан, мэдээллийг гаргаж, танилцуулсан байх;<br><br>-Энэ чиглэлээр холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажилласан байх; | I-IV | |
| 57. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.5 дугаар арга хэмжээ-Мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах шаардлагын мөрөөр ажиллах; /ЭХХШтХ 29.6.2/ | УССГХ | Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасан "Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх" үүргийг гүйцэтгэлийг хангуулах | 2021 онд нийт 40 мэдэгдлийн мөрөөр ажиллав. Мөрдөгчийн мэдэгдлийн цахим сан бүрдүүлэх зорилгоор Khutulbur.iaac.mn цахим сангийн "Мөрдөгчийн мэдэгдэл" дэд санд 218 мэдэгдлийг бүрэн оруулж, зохих баяжилтыг хийж, судалгааны ажилд ашиглах боломж бүрдүүлэв. Тухайлбал, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн Өргөө амаржих газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар, тус газрын харьяа Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Монголросцветмет" ТӨҮГ, "ДЦС-2" ТӨХК, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Баян-Өлгий аймаг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Цагдаагийн ерөнхий газарт, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын Ерөнхий газар, Нийслэлийн Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэст ажиллав. | Мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн мөрөөр шаардлагатай бол газар дээр нь ажиллаж, авлигын гэмт хэрэг, зөрчил гарах болсон шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлийг арилгах, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөхцөлийг бүрдүүлсэн байх; | I-IV | |
| 58. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.6 дугаар арга хэмжээ-Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээний дүрс бичлэг, зураг, нэвтрүүлэг, видео, реклам ном гарын авлага, сурталчилгааны материалын эхийг төвлөрүүлэх, тухайн жилд үүссэн баримтуудаар | УССГХ | Зохион байгуулсан ажил арга хэмжээний дүрс бичлэг, зураг, нийтлэл, нэвтрүүлэг, видео, реклам, анимейшн, видео баннер, сурталчилгааны ном гарын авлага, зурагт хуудас, холбогдох бусад материалын эхийг сар тутамд төвлөрүүлж бүртгэл хөтөлсөн байх; | Зохион байгуулсан ажил арга хэмжээний дүрс бичлэг, зураг, нийтлэл, нэвтрүүлэг, видео, реклам, анимейшн, видео баннер, сурталчилгааны ном гарын авлага, зурагт хуудас, холбогдох бусад материалын эхийн бүртгэл хөтөлж, сар тутамд төвлөрүүлж, сан үүсгэн ажиллаж байна. Энэ хүрээнд Өдөр тутмын "Өнөөдөр", "Өдрийн сонин", "Үндэсний шуудан" сонинд нийтлэгдсэн нийтлэл, мэдээллээр архив үүсгэж байгаа. | -Байгууллагын сурталчилгааны эх нэг цэгт төвлөрч урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд ашиглах сан үүссэн байна.<br>-Мэдээ, мэдээлэл 1 цэгт төвлөрснөөр үйл ажиллагаа хөнгөвчлөгдөж, нэгдсэн байдлаар мэдээ, мэдээлэл авах, нийтлэх, нэвтрүүлэх, шинэчлэх, боловсронгуй болгох нөхцөл бүрдсэн байна. | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | архивын нэгж үүсгэж архивт шилжүүлэх; | | -Тухайн жилд үүссэн баримтуудаар архивын нэгж үүсгэж архивт шилжүүлсэн байх; | | | | |
| 59. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.7 дугаар арга хэмжээ-Олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох;<br>ГХУСтХ 37-р зүйл/ | УССГХ | | Засгийн газрын 2021.04.28-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан. ГХУСАЗЗ-ийн 2021.10.01-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл” байгуулж, дээрх журмыг хэрэгжүүлэхийг даалгасан. | 1-2 дугаар улиралд-Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх чиглэлийг тодорхойлж, Аймаг, нийслэл, түүний харьяа байгууллагаас 2022 онд хэрэгжүүлэх олон нийтийн хяналтын чиглэлийн жагсаалтыг гаргах “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-д танилцуулан шийдвэр гаргуулсан байх;<br>-Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх иргэн, иргэдийн бүлэг, судалгаа шинжилгээний болон төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг аймаг, нийслэлийн ГХУСАЗСЗ-тэй хамтран зохион байгуулсан байх;<br>Жилдээ-Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгон шалгарсан иргэн, иргэдийн бүлэг, ТББ, судалгаа шинжилгээний байгууллагыг арга зүйн удирдлагаар хангах, сургалт зохион байгуулах; | I-II<br>I-IV | |
| 60. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.8 дугаар арга хэмжээ-Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээний 2022 оны судалгаа /төрийн үйлчилгээ авсан иргэд, төрийн албан хаагч, бодлого боловсруулагч, судлаачид зэрэг шинжээч/-г зохион байгуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэх; | США<br>УССГХ | -Ажлын даалгавар тодорхой болсон байх;<br>-Үнэлгээ хийх ТББ-ыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байх;<br>-Үнэлгээний тайланг хүлээн авсан байх;<br>-Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байна. | -Жил тутамд төсөөллийн судалгааг хийж, олон нийтэд мэдээлдэг.<br>-“Шударга байдлын үнэлгээ”-ний 2021 оны судалгааг гүйцэтгэж, дүнг танилцуулах, мэдээлэх ажлыг зохион байгуулав. Шударга байдлын үнэлгээнд 2021 онд 46 яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар зэрэг нийт 68 байгууллагыг хамруулсан. Тооцооллоор Шударга байдлын үнэлгээ 72.9 гарсан нь 2019 оныхоос 1.2 пунктээр буурсан байна. Шударга байдлын үнэлгээний дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулаа. | -Судалгааны тайланг хүлээн авсан байх;<br>-Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байх;<br>-Зөвлөмж өгч, зөвлөмжийн үр дүнг тооцсон байх;<br>-Судалгааны үр дүнд суурилан зорилтот урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил,арга хэмжээ зохион байгуулагдсан байх; | I-III | |
| 61. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.9 дүгээр арга хэмжээ-Төрийн үйлчилгээний давхардлын талаарх судалгаа хийж, тайланг боловсруулах; | США | - Дүүргүүдийн нэг цэгийн үйлчилгээ болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээс иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, тэнд хандаж, үйлчилгээ авсан иргэдийн бүртгэл, статистикийн талаарх судалгаа хийсэн байх;<br>- Судалгааны тайланг хүлээн авсан байх;<br>“Хорооноос иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, хороонд хандаж, үйлчилгээ авсан иргэдийн бүртгэл, статистикийн талаарх судалгаа”-ны тайлантай нэгтгэн арга хэмжээний биелэлтийг гаргасан байх. | 2021 онд Хорооноос иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, хороонд хандаж, үйлчилгээ авсан иргэдийн бүртгэл, статистикийн талаарх судалгааг “Дэлгэрэнгүй хууль” ТББ-аар гүйцэтгүүлж байгаа. Нийслэлийн 9 дүүргийн 176 хорооноос байршил хүн ам зүйн онцлог зэргийг харгалзан 45 хороог сонгон авч хорооноос үзүүлж буй төрийн үйлчилгээний төрөл, хэлбэр, хуульд заасан боловч бодит байдал дээр үзүүлдэггүй, цөөн үзүүлдэг үйлчилгээ, иргэдэд үзүүлэх шаардлагагүй үйлчилгээ, хуульд заагаагүй боловч бодит байдал дээр үзүүлдэг үйлчилгээ, цаашид үзүүлэх шаардлагатай үйлчилгээ, иргэдэд үзүүлдэг боловч өөр байгууллагаас мөн авч болох төрийн үйлчилгээ, цаашид хувийн хэвшил, мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагатай үйлчилгээ болон төрийн үйлчилгээ авсан иргэдийн талаарх бүртгэлийг хөтөлсөн байдлын талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж байна. | - Судалгааны ажлын даалгавар боловсруулж батлуулсан байна.<br>- Судалгааг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт зарласан байна.<br>- Гүйцэтгэгчийн ирүүлсэн тайланг нягталж, хүлээн авсан байна.<br>-Төрийн үйлчилгээний давхардлын талаарх судалгааны нэгдсэн тайланг боловсруулсан байна. | II | |
| 62. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.10 дугаар арга хэмжээ: Улс төрийн хүрээн | США<br>УССГХ | -Ажлын даалгавар тодорхой болсон байх; | -Жил бүр төсөөллийн судалгааг хийж, олон нийтэд мэдээлдэг. | -Судалгааны тайланг хүлээн авсан байх;<br>-Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байх;<br>-Зөвлөмж өгч, зөвлөмжийн үр дүнг тооцсон байх; | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэх авлигын талаарх төсөөллийн судалгааг зохион байгуулах; | | -Үнэлгээ хийх ТББ-ыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байх;<br>-Үнэлгээний тайланг хүлээн авсан байх;.<br>-Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байна. | -Улс төр, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөллийн судалгаагаар 2021 онд улс төрийн хүрээн дэх авлигын түвшин 3.82 пункт, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин 3.85 пункт гарсныг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад улс төрийн хүрээн дэх авлигын түвшин 0.16 пунктээр буурсан. | -Судалгааны үр дүнд суурилан зорилтот урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил,арга хэмжээ зохион байгуулагдсан байх; | | |
| 63. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.11 дүгээр арга хэмжээ-Шүүх, хууль хяналтын байгууллага дахь авлигын талаарх төсөөллийн судалгааг зохион байгуулах; | США<br>УССГХ | -Ажлын даалгавар тодорхой болсон байх;<br>-Үнэлгээ хийх ТББ-ыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байх;<br>-Үнэлгээний тайланг хүлээн авсан байх;.<br>-Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байна. | Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын шалгуур үзүүлэлт 2021 онд авлигын цар хүрээ 3.57 гарсан нь өмнөх оныхоос -0.15 пунктээр буурчээ. Харин авлигын хэлбэрийн индекс нь 3.73 гарч өнгөрсөн оноос +0.02 пунктээр өссөн. Харин авлигын шалтгаан нөхцөлийн индекс 4.14 гарч өмнөх оноос +0.03 пунктээр нэмэгдсэн бол, авлигын хор уршиг, үр дагаврын индекс 3.98 гарч 2020 оноос мөн +0.14 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин өмнөх оны үзүүлэлтээс 0.03 пунктээр өссөн байна. | -Судалгааны тайланг хүлээн авсан байх;<br>-Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байх;<br>-Зөвлөмж өгч, зөвлөмжийн үр дүнг тооцсон байх;<br>-Судалгааны үр дүнд суурилан зорилтот урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил,арга хэмжээ зохион байгуулагдсан байх; | I-IV | |
| 64. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.12 дугаар арга хэмжээ-Авлигын эрсдэлийн үнэлгээг хийх; /Алсын хараа 2050-5.6./ | США<br><br>УССГХ | -Үнэлгээ хийх хүрээг тогтоож, ажлын даалгавар хийгдсэн байх;<br>-Үнэлгээ хийх ТББ-ыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байх;<br>-Үнэлгээний тайланг хүлээн авсан байх;<br>-Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байна | Төрийн байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээг Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв, Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, Зээлийн батлан даалтын сан, Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Дорнод бүсийн эрчим хүчний систем, Хөдөө аж хуйг дэмжих сан, Шинжлэх ухаан технологийн сан, Замын Үүд дэх гаалийн газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар /14/-т гэрээгээр гүйцэтгүүлэв. Эрсдэлийн үнэлгээгээр дээрх байгууллагуудын үйл ажиллагаа, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн чиглэлийн үйл ажиллагаа, байгууллагын удирдлагуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, бүртгэл хөтлөлтөд авлигын эрсдэлийн түвшин өндөр үнэлэгдсэн. Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудад авлигын эрсдэлийн тайланг танилцуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлөө. | -Судалгааны тайланг хүлээн авсан байх;<br>-Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байх;<br>-Зөвлөмж өгч, зөвлөмжийн үр дүнг тооцсон байх;<br>-Судалгааны үр дүнд суурилан зорилтот урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил,арга хэмжээ зохион байгуулагдсан байх;<br><br>Үнэлгээний мөрөөр:<br><br>-Шинжлэх ухаан, технологийн сан, Хөдөө аж ахуйг дэмжих сан, Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газарт ажиллана.<br><br>-Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Замын-Үүд дэх Гаалийн газарт ажиллаж, үр дүнг танилцуулсан байх;<br><br>-Эрсдэлийн үнэлгээ хийгдсэн бусад байгууллагад ажиллаж, үр дүнг танилцуулсан байх; | I-IV<br><br>I<br><br>II | |
| 65. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.13 дугаар арга хэмжээ Хүүхдийн шударга байдал 2022 оны судалгааг зохион байгуулах; | США<br>УССГХ | -Үнэлгээ хийх хүрээг тогтоож, ажлын даалгавар хийгдсэн байх;<br>-Үнэлгээ хийх ТББ-ыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байх;<br>-Үнэлгээний тайланг хүлээн авсан байх;<br>-Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байна | -2021 онд энэ судалгаа хийгдээгүй. | -Судалгааны тайланг хүлээн авсан байх;<br>-Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байх;<br>-Зөвлөмж өгч, зөвлөмжийн үр дүнг тооцсон байх;<br>-Судалгааны үр дүнд суурилан зорилтот урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил,арга хэмжээ зохион байгуулагдсан байх; | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 66. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.14 дүгээр арга хэмжээ Төрийн байгууллагаас 2019, 2020 онд зарласан худалдан авах ажиллагаан дахь авлигын нөхцөл байдлын судалгааг хийх | США | -Судалгааны ажлын даалгавар боловсрогдсон байх;<br>-Судалгааны багийг сонгон шалгаруулсан байх;<br>-Ажлын тайланг хүлээн авч, зөвлөмжийг боловсруулж талуудад хүргүүлсэн байх;<br>-Судалгаа хийгдэж, цаашид авах арга хэмжээний санал, ажлын чиглэл тодорхой болсон байх;<br>-Судалгааны тайланг хүлээн авсан байх;<br>-Үр дүнг тооцсон байх;<br>-Цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний санал тодорхой болсон байх; | -2021 онд энэ зорилтот судалгаа хийгдээгүй. | -Судалгааны тайланг хүлээн авсан байх;<br>-Үр дүнг тооцсон байх;<br>-Цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний санал тодорхой болж, үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдсэн байх; | I-IV | |
| 67. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.15 дугаар арга хэмжээ "Сонгуулийн санхүүжилтийн талаарх судалгаа" хийх; | США | | -2021 онд энэ судалгаа хийгдээгүй. | -Судалгааны тайланг хүлээн авсан байх;<br>-Үр дүнг тооцсон байх;<br>-Цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний санал тодорхой болж, үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдсэн байх; | I-IV | |
| 68. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.16 дугаар арга хэмжээ-Авлигын нөхцөл байдлын системийн динамик загварчлал боловсруулах; | США | | -2020 онд эхэлсэн энэ судалгаа 2021 онд үргэлжилсэн. | -Судалгааны тайланг хүлээн авсан байх;<br>-Үр дүнг тооцсон байх;<br>-Цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний санал тодорхой болж, үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдсэн байх; | I | |
| 69. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.17 дугаар арга хэмжээ "Шударга ёс" онол, арга зүйн сэтгүүлийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын талаар судалж, эрх зүй, зохион байгуулалтын шинжтэй шаардлагатай арга хэмжээг авч, үр дүнг танилцуулах; | США | -Судалгаа хийгдэж, санал шийдвэрлэгдсэн байх;<br>-Эрх зүй, зохион байгуулалтын шинжтэй шаардлагатай арга хэмжээг авч, хүлээн зөвшөөрөгдөж баталгаажсан байх; | Олон нийтийн авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор жил бүр 2 дугаар хэвлэн олон нийтэд үнэгүй тараагддаг болովч эрдэм, шинжилгээ, судалгааны бүтээл нийтлэхэд кредит тооцдоггүй, нэгдсэн бодлого хангалтгүй, эрх зүйн зохицуулалтгүй, олон улсын стандарт дугаар аваагүй болно. | -Онол, арга зүйн сэтгүүлд тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна. | I | |
| 70. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.18 дугаар дүгээр арга хэмжээ-"Шударга ёс" онол-арга зүйн цуврал сэтгүүлийг эмхлэн хэвлүүлэх, | США | -Сэтгүүлд хэвлүүлэх баримт материалыг төвлөрүүлсэн байх;<br>-Редакцийн зөвлөлөөр хэлэлцэж сонгож хэвлүүлсэн байх;<br>-Түгээлт хийсэн байх; | Олон нийтийн авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор жил бүр 2 дугаар хэвлэн олон нийтэд үнэгүй тараагддаг. 2021 онд 1 дугаар хэвлэгдсэн. | -Тогтоосон хугацаанд хэвлэгдэж, түгээгдсэн байх; | I, IV | |
| 71. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.19 дүгээр арга хэмжээ-АТГ-ын Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | США | -Авлигатай тэмцэх газрын стратеги төлөвлөгөөний өнгөрсөн 2 жилийн хэрэгжилтэд мониторинг хийх; | - | -Стратеги төлөвлөгөөнд анхаарах асуудал, оруулах өөрчлөлт, тохиргоотой холбоотой санал боловсруулж, шийдвэрлүүлсэн байна. | I-II | |
| 72. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.20 дугаар арга хэмжээ-Өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын утсаар мэдээлэл хүлээн авах ажилд техник, технологи нэвтрүүлэх, яриаг бичвэрт хөрвүүлэх зэрэг технологийг судалж, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах; | США<br>АБХША | -Холбогдох техник технологийн судалгаа хийгдсэн байх;<br>-Үйл ажиллагаанд ашигладаг болсон байх; /түвшин ахисан байх;/ | - | Өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах, ялангуяа 110 дугаарын утсаар мэдээлэл хүлээн авах ажилд техник, технологи, яриаг бичвэрт хөрвүүлэх зэрэг технологийг үйл ажиллагаанд ашигладаг болсон байна. | I-II | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 73. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.21 дүгээр арга хэмжээ-“Авлигын системийн динамик загвар-2” ын гол хувьсагчуудыг тогтоож, учир шалтгааны диаграмыг боловсруулах | США | “Авлигын системийн динамик загвар-2”-ын гол хувьсагч, учир шалтгааны диаграмыг боловсруулж, танилцуулсан байх; | “Монгол Улс дахь авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийн динамик загвар боловсруулах” судалгааны ажил хийгдэж байгаа. | - Ажлын удирдамж, экспертийн ярилцлагын асуултыг боловсруулж, батлуулсан байна.<br>- Удирдамж, бэлтгэсэн асуултын дагуу экспертийн ярилцлага зохион байгуулсан байна.<br>-Ярилцлагын үр дүнд загварын гол хувьсагчуудыг тогтоож, учир шалтгааны диаграммыг боловсруулсан байна. | IV | |
| Хоёрдугаар хэсэг. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ<br>/ хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг / | | | | | | | |
| Гүйцэтгэлийн зорилт № 2.2 Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, ХАСУМ-ийг хянах, төлөвлөгөөт болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| Гүйцэтгэлийн зорилт № 2.2.1. Улсын хэмжээнд мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулж арга зүйн удирдлагаар ханган ажиллах, бүртгэл, дүн мэдээг нэгтгэн боловсруулж, олон нийтэд мэдээлэх; | | | | | | | |
| 74. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1.1 дүгээр арга хэмжээ-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, мэдээлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах; /АЭХ 10.6, 11.1, 11.4, 11.5, НАНбХАСЗАСЗУСтХ 24.1.1, 24.3/ | ХШДШХ АБХШНА | -Албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн бүртгэсэн байна. | Мэдүүлгийн бүрдүүлэлтийн дүнг нэгтгэхэд улсын хэмжээнд Төрийн захиргааны болон нутгийн захиргааны нийт 117 байгууллагын 43692 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж бүртгүүлэхээс хуулийн хугацаанд 43692 мэдүүлэг гаргагч /цахим-38947, цаасаар-4745/ буюу 100 хувь нь мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаж баталгаажуулан бүртгүүлсэн байна. Мөн ХАСХОМ-ийг мэдүүлэхтэй холбоотой асуудлаар мэдүүлэг гаргагч албан тушаалтан нь хуулийн хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэх үүргийн талаарх сурталчилгааны шторкыг олон нийтэд хүргэх, нийгмийн хариуцлагын үүргээ хэрэгжүүлэн ажиллах талаар МҮОНТ, ТВ-9, Монгол HD зэрэг нийт телевизийн захиргаанд бичиг хүргүүлж, мөн Өдрийн сонин, Өнөөдөр сонин болон АТГ-ын цахим сайт, www.news.mn, www.ikon, www.medee.mn сайтуудад хуулийн хугацаа сануулсан баннерыг байршуулах зэргээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллав.<br>2021 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын нөхөн сонгуульд нэр дэвшсэн этгээдүүдийн ХОМ-ийг бүргэх, хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулав. Үэр дэвшигчдийн ХОМ-ийн хураангуйг тус газрын http://xacxom.iaac.mn/ цахим системд хуулийн хугацаанд байршуулсан болно. | -АТГ-т мэдүүлгээ гаргадаг төрийн өндөр албан тушаалтны нэгдсэн судалгааг гаргаж, шилжилт хөдөлгөөн болон цахим системд хяналт тавих хуваарийг шинэчилсэн байна.<br>-Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргах, хугацаа сануулсан, мөн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг сурталчилсан шторкийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээж, сурталчилсан байна.<br>-Төрийн захиргааны төв, орон нутгийн нийт 109 байгууллагын мэдүүлэг гаргагч албан тушаалтан болон тэдгээрийн салбар нэгжийн эрх бүхий албан тушаалтнуудад сургалт зохион байгуулж, мэдээлэл арга зүйгээр хангасан байна.<br>-ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцсон байх.<br>-Програмын хэвийн, найдвартай, нууцлал, аюулгүй байдлыг ажиллагааг хангаж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байх; | I-II | |
| 75. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1.2 дугаар арга хэмжээ-ХАСХОМ гаргах хууль тогтоомжийн биелэлтийн талаар мэдээллийг хуулийн хугацаанд УИХ-ын Хууль зүйн Байнгын хороонд хүргүүлэх, ХОМ гаргах журмын биелэлтийн талаар олон нийтэд мэдээлэх, ҮАБЗ, Үндэсний статистикийн хороонд холбогдох мэдээ, тайланг хүргүүлэх; АЭХ 10.6, | ХШДШХ | -Төрийн албан хаагчдын болон сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, явц байдлын талаарх танилцуулга мэдээлэл бэлтгэн ҮАБЗ, УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, хуульд заасан хугацаанд хүргүүлсэн байх;<br>-Нийтийн албан тушаалтны болон сонгуульд нэр дэвшигчдийн ХОМ-ийг | -Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт заасны дагуу хуулийн хугацаа дууссанаас хойш 14 хоногийн дотор холбогдох байгууллагууд нь тайлан мэдээг Авлигатай тэмцэх газарт ирүүлэх үүрэгтэй бөгөөд 2021.03.01-ээс улсын хэмжээний нэгдсэн дүн мэдээг гаргаж, Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт заасныг үндэслэн хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хороо, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллав.. | -АТГ-ын албан хаагчдын 2021 оны ХАСХОМ-ын баталгааны маягтын эх хувийг холбогдох тайлан, бүртгэл, нэрсийн жагсаалтын хамт, 2021 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа болон албан тушаалтнуудын 2021 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчилсэн бүртгэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээлэл, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүртгэлтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг УИХ-ын ХЗБХ-д, “Төрийн албан хаагчдын ХАСХОМ-ийн бүрдэлт, явц байдлын | II | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 11.1, 11.4, 11.5, НАНбХАСЗАСЗУСтХ 24.1.1, 24.3/ | | нээлттэй мэдүүлэх техникийн боломжийг бүрдүүлсэн байх; | - Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар зарлигаар баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам"-ын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэгт заасныг үндэслэн "Төрийн албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдэлт, явц байдлын талаар" танилцуулах тойм мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндэсний статистикийн хороонд хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан. | талаар" танилцуулах тойм мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн байх;<br>-ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн тайлан, мэдээг нэгтгэн Үндэсний статистикийн хороонд хүргүүлж албан ёсны захиргааны статистикийг бүрдүүлсэн байх; | | |
| 76. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1.3 дугаар арга хэмжээ-Мэдүүлгийн цахим системийн хөгжүүлэлтийг тухай бүр хийх, цахим мэдээллийн баазыг ашиглан судалгаа дүн шинжилгээ хийж, хяналтыг сайжруулах;<br>/Алсын хараа 2050-5.6.8, ГТ-1.11.3.1, 1.11.3.13/ | ХШДШХ | -Цахим сангийн мэдээлэлд үндэслэн албан тушаалтны хөрөнгө, орлогын өсөлт бууралтад дүн шинжилгээ хийж, зөрчил илрүүлэлтийн үзүүлэлт өссөн байна.<br>-Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Цахим системийг боловсронгуй болгоход шаардлагатай төсвийг шийдвэрлүүлж, цахим системийг цогц байдлаар шинэчлэх ажлыг эхлүүлээд байна. Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг үндэслэн нэг тэрбумаас дээш хэмжээгээр орлого нь өссөн болон давтамжтайгаар өсч байгаа 24 албан тушаалтны цэвэр хөрөнгийн байдалд харьцуулсан дүн шинжилгээ хийв. Тэрбум төгрөгөөс дээш хэмжээгээр компанийн ногдол ашиг болон хөрөнгө борлуулсны орлого мэдүүлсэн нь татварын байгууллагад гаргасан тайлан, мэдээтэй нийцэж байгаа эсэхийг шалгуулах зорилгоор 20 мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн гишүүдийн нэмэгдсэн хөрөнгө, орлогын мэдээллийг шалгуулахаар Татварын ерөнхий газарт албан бичгээр хүргүүлсэн болно. | Эхний хагас жилд-Цахим сангийн шинэчлэл үе шаттай хийгдсэн байна.<br>-Цахим сангийн мэдээлэлд /Data clearing/ хийсэн байна.<br>-Татварын ерөнхий газартай хамтран ажиллаж үр дүнг тооцсон байна.<br><br>Сүүлийн хагас жилд: Төрийн аудитын болон бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж эрсдэлийг бууруулах, таслан зогсоох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | I-IV | |
| Гүйцэтгэлийн зорилт № 2.2.2 Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянаж, дүн шинжилгээ хийх; | | | | | | | |
| 77. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.2.1 дүгээр арга хэмжээ-Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж, мэдэгдэх; НАНбХАСЗАСЗУСтХ 23.5/ | ХШДШХ | -Нийтийн албан тушаалтын ХАСУМ-ийг хуульд заасны дагуу хянасан байх; | 2021 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 12504 этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авснаас 12468 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн бөгөөд Хянан шалгасан мэдүүлгээс ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож анхааруулсан 11162, Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод нийцүүлэн томилохыг анхааруулсан 1018, хууль, журамд заасан шаардлага хангаагүй үндэслэлээр 266 мэдүүлгийг буцаан хүргүүлсэн, мөн 22 нэр дэвшигчийг тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон талаарх дүгнэлтийг холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн байна. | -Төрийн захиргааны төв болон орон нутгийн салбар нэгж байгууллагын хэмжээнд албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн нэр дэвшигчийн ХАСУМ-ийг хянаж, тоон мэдээлэл, гарсан дүгнэлтэд судалгаа хийсэн байна.<br>-Дүн шинжилгээг хийж, үнэлэлт дүгнэлт гаргах, дүгнэлтэд тулгуурлаж Зөвлөмж өгч, үр дүнг тооцсон байна. | I-IV | |
| Гүйцэтгэлийн зорилт № 2.2.3 Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; /хориглолт, хязгаарлалт, бусад/ | | | | | | | |
| 78. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.3.1 дүгээр арга хэмжээ-Нийтийн албанд гарч байгаа авлига, ашиг сонирхлын зөрчлийн шалтгаан, нөхцөлийг | ХШДШХ | -"Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг | -АТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компани, аж ахуйн нэгж, түүний харьяа хараат болон охин компани нийт 74 компаниудын нийт ажилтнуудын ажлын байрны чиг үүрэгт дүн шинжилгээ хийсэн. Авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлтэй 404 албан тушаалтан байсан тул | Эхний хагас жилд-Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцсон байх;<br>-США-тай хамтран Нийтийн албанд гарч байгаа авлига, ашиг сонирхлын зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, дүн шинжилгээ хийх. | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоож, дүн шинжилгээ хийх, үр дүнг үйл ажиллагаанд ашиглах; | | сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн зөрчлүүдэд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан, нөхцөлийг тогтоосон байна.<br>-Холбогдох арга хэмжээ авсан байх; | тэдгээрийг Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамруулж, мэдүүлэг гаргавал зохих удирдах болон эрх бүхий тушаалтнаар тодорхойлох тухай зөвлөмж, чиглэлийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрчим хүчний яам, Зам, тээврийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, УБТЗ, “Эрдэнэс таван толгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК түүний харьяа байгууллагуудад бичгээр зөвлөмж хүргүүлэв. Улаан туг буюу “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт эрсдэл тооцох аргачлал”-ын дагуу албан тушаалтнуудын мэдүүлэгт эрсдэл тооцож байгаа нь мэдүүлгийн хяналтын үйл ажиллагааг оновчтой болгоход дэмжлэг болж байна. Цаашид цахим системийг хөгжүүлэх ажлын хүрээнд бусад байгууллагуудын мэдээллийн сантай холбож, аргачлалыг тооцооллыг бүрэн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. | Сүүлийн хагас жилд-Улаан туг буюу “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт эрсдэл тооцох аргачлал”-ын дагуу албан тушаалтнуудын мэдүүлэгт эрсдэлийг тооцож, холбогдох арга хэмжээ авч, үр дүнд хүрсэн байх; | III-IV | |
| Гүйцэтгэлийн зорилт № 2.2.4 Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, тэдний ур чадварыг нэмэгдүүлэх; | | | | | | | |
| 79. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.4.1 дүгээр арга хэмжээ-Төрийн захиргааны болон орон нутгийн салбар, нэгжийн мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах; /УИХ ХЗБХ 2021 05 дугаар тогтоол/ | ХШДШХ | -Шинээр томилогдсон ЭБАТ-ыг сургалтад хамруулж, мэдлэг олгох, ур чадварын түвшинг нэмэгдүүлэх, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч, сургалтад хамруулсан байх;<br>-Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хэрхэн бүртгэх, хянахтай холбоотой асуудлаар ЭБАТ-д нэгдсэн арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байх6 | Мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2021 оны үйл ажиллагааны бэлтгэлийн хүрээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллагын бүх ЭБАТ-ыг хамруулсан цахим сургалтыг зохион байгуулав.<br>Мөн ЭБАТ-ын судалгааг шинэчлэн гаргаж 2021 оны I, II дугаар улиралд шинээр томилогдсон ЭБАТ-д зориулсан сургалтыг 2021 оны 2 дугаар сарын 10 болон 2021 оны 6 дугаар сарын 7-нд хоёр удаа зохион байгуулав. 2021 оны сүүлийн хагас жилд томилогдсон болон 2022 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн бэлтгэл ажлыг хангахтай холбоотой ЭБАТ-д зориулсан сургалтыг онлайн болон танхимын зохион байгуулалтаар 2022 оны 12 дугаар сарын 23-24-ний өдөр зохион байгуулахаар сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулж, сургалтын бэлтгэл ажлыг хангаад байна.<br>ЭБАТ-д зориулсан мэдээлэл, арга зүйн дэмжлэг өгөх ажлыг “ЭБАТ-мэдээлэл” фэйсбүүк групп болон утас, и-мэйлээр дамжуулан тухай бүр өгч ажиллаж байна. “ЭБАТ мэдээлэл” группэд 1500 гаруй ЭБАТ нэгдсэн бөгөөд мэдүүлэг гаргагч болон ЭБАТ-д зориулсан гарын авлага, зөвлөмж, мэдээлэл, зааварчилгаа болон бусад цаг үеийн шинжтэй мэдээллийг тухай бүр тогтмол байршуулж, ирүүлсэн хүсэлт, асуултад тогтмол хариулт өгч ажилласан нь үр дүнтэй байв. | Жилдээ:<br>-ЭБАТ-ын судалгааг гаргаж, шинээр томилогдсон ЭБАТ-д сургалт зохион байгуулах<br>-ХАСХОМ бүрдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах ажиллагаа хуульд заасны дагуу явагдах нөхцөл бүрдсэн байна.<br>-Сургалт зохион байгуулсан байх;<br>-Мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол хангасан байх; | I-IV | |
| Гүйцэтгэлийн зорилт № 2.2.5 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллаас ирүүлсэн Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэх; | | | | | | | |
| 80. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.5.1 дүгээр арга хэмжээ-Өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч хянан шалгах, үр дүнг тооцох; | ХШДШХ | -Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгасан байх;<br>-Шийдвэрлэлтийн хувь өссөн байх.<br>-Зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэсэн | 2021 онд албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийн 560, өмнөх оны үлдэгдэл 40, нийт 600 гомдол, мэдээллийг хүлээн авснаас тайлант хугацаанд 561 хянан шийдвэрлэсэн, 39 гомдол, мэдээлэл ажиллагаанд хянагдаж байна. Тайлант хугацаанд хууль бус томилгоо, шаардлага хангаагүй, ял шийтгэлтэй этгээдийг нийтийн албанд | Жилдээ:<br>-Өргөдөл, гомдол, мэдээллийн хяналт шалгалтад чанарын ахиц гарч, шийдвэрлэлтийн хувь, чанар өмнөх оны мөн үеэс өссөн байна.<br>-Өргөдөл, гомдол, мэдээлэл гаргасан иргэн, хуулийн этгээдэд шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | /АЭХ 9, 13.5, 18.4.6, НАНбХАСЗАСЗУСХ 26.4, 26.5/ | | талаарх мэдээллийг өөрийнх нь зардлаар олон нийтэд мэдээлэх, түүнчлэн зөрчлийн шалтгаан нөхцөл, хор уршгийг арилгах чиглэлд УССГХ-тай хамтран ажилласан байх;<br>-Авлигын гэмт хэргийн шинжтэй зөрчил илэрсэн тохиолдолд шалгуулахаар эрх бүхий нэгжид шилжүүлэх, бусад хэлтэстэй хамтран ажилласан байх; | томилсон, хуурамч диплом ашиглаж төрийн албанд ажиллаж байгаа, хамаарал бүхий этгээдтэй холбоотой тушаал, шийдвэр гаргасан гэх агуулгатай гомдол, мэдээллийн тоо өссөн байх бөгөөд гомдолд дурдсан асуудлын хүрээнд нийт 30 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан. Мөн албан тушаалтны ёс зүй, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр нийт 60 байгууллага албан тушаалтанд зөвлөмж, чиглэлийг хүргүүлж биелэлтийг ханган ажилласан.<br>Шалгалтаар гэмт хэргийн шинжтэй буюу албаны эрх мэдлээ хэтрүүлсэн, урвуулсан, бусдад давуу байдал олгосон, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан байж болзошгүй гэх үндэслэлээр нийт 74 гомдол, мэдээлэл буюу нийт гомдлын 13.1 хувийг Мөрдөн шалгах хэлтэс, Гүйцэтгэх ажлын хэлтэст шалгуулахаар шилжүүлсэн. | гомдлын хариуг тухай бүрт албан бичиг, амаар мэдэгдэж мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн байна.<br>-Өргөдөл, гомдол мэдээллийн шийдвэрлэх хугацаа сунгах тохиолдлыг тодорхой хэмжээнд бууруулж, анхны хугацааны шийдвэрлэлт өссөн байна.<br>-Шалгалтын явцад илэрсэн авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой гомдол, мэдээллийг тухай бүрт холбогдох хэлтэс, албадад хүргүүлж, хамтын ажиллагаа сайжирсан байна. | | |
| Гүйцэтгэлийн зорилт № 2.3 Авлигын эсрэг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах; | | | | | | | |
| 81. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.1 дүгээр арга хэмжээ-Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд, хуульд заасан үндэслэл, журмын дагуу бүрэн шалгаж, шийдвэрлэх; /Алсын хараа 2050-5.6.6/ | МШХ | -Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг бүрэн хүлээн авч, бүртгэсэн байх;<br>-Гомдол, мэдээллийг байгууллагын цахим сан болон прокурорын хяналтад оруулсан байх;<br>-Гомдол , мэдээллийн тоо мэдээ үнэн зөв гарсан байх; | Байгууллагын хэмжээнд Байгууллагын хэмжээнд 2021 онд өмнөх оны 105, энэ оны 1491 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, нийт 1596 гомдол, мэдээллийг хүлээн авснаас 329 гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлсэн. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл өмнөх оны мөн үеэс 234 нэгжээр буюу 17.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1144 гомдол, мэдээллээс 460 гомдол, мэдээлэл буюу 40.2 хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 594 гомдол, мэдээлэл буюу 51.9 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 44 гомдол, мэдээлэл буюу 3.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, 46 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 96.0 хувьтай байна. | Гомдол мэдээллийн шийдвэрлэлт 96.2 хувьд хүрсэн байна. | I-IV | |
| 82. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.2 дугаар арга хэмжээ-Хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй хууль зөрчсөн бусад үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх, энэ хуулийн 6.6, 7.1.7, 7.1.8-д заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх; /Алсын хараа 2050-5.6.6/ | МШХ | -Тухай бүр холбогдох мэдээллийг холбогдох хэлтэст шилжүүлсэн байх;<br>-Энэ тухай бүртгэл хөтлөгдсөн байх;<br>-Улирал тутамд дүн гаргасан байх;<br>-Хэлтэс, албадын хамтын ажиллагааг хангасан байх; | Хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй буюу авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй 7 үйлдлийг шалгуулахаар харьяалах хэлтэст шилжүүлж хянан шалгах боломжийг бүрдүүлэв. Тайлант хугацаанд шалгасан нийт мэдүүлгийн 60 буюу 10.3 хувийг МШХ, ГАХ-ээс шилжүүлснээр шалгасан байна. | Эхний хагас жилд: Хуулийн хэрэгжилт хангагдаж, бүртгэл судалгаатай болсон байна. Сүүлийн хагас жилд: Хуулийн хэрэгжилт хангагдаж, бүртгэл судалгаатай болсон байна | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 83. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.3 дугаар арга хэмжээ-Мөрдөн шалгах ажиллагааг хуулийн дагуу шуурхай явуулж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нийт хэргийн 63.0 хувийг шийдвэрлэх;<br>/Алсын хараа 2050-5.6.6/ | МШХ | -Мөрдөн шалгах ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах замаар гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шуурхай зохицуулалт хийсэн байх;<br>-Шийдвэрлэх хэргийн графикийн биелэлтийг тухай бүр гаргасан байх;<br>-Хавтаст хэргийн болон хэргийн шийдвэрлэлтийн график хоцорсон, удааширч байгаа хэрэгтэй материалтай биечлэн танилцах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, мөрдөгчид дэмжлэг үзүүлэх зорилгоор бичгээр зааварчилга өгч, биелэлтийг хангуулах;<br>-Шийдвэрлэх хэргийн график гаргаж, прокурорын байгууллагатай хамтран баталсан байх; | Тайлант хугацаанд хуульд заасан харьяаллын 1543 үйлдэлтэй, 909 холбогдогчтой, 1307 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1,8 хувиар буурсан байна. /2020 онд 1331/ Нийт шалгасан хэргийн 269 буюу 20.6 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай, 429 буюу 32.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, 61 буюу 4.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 63 хэргийг нэгтгэн шалгаж, 5 хэргийг түдгэлзүүлж, одоо 480 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн 399 хэрэг, мөрдөн байцаалтын 81 хэрэг байна. 2020 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1331 хэргээс 236 буюу 17.7 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж байсан бол 2021 онд 1307 хэргээс 269 хэргийг буюу 20,6 хувийг шилжүүлсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 2.9 хувиар өсч, хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 5.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 62.9 хувьтай байгаа бөгөөд шүүхээр 160 буюу 42,4 хувь нь хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн байна. | Эхний хагас жилд:<br>-Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлтийг өмнөх оны мөн үеэс ахиулсан байна.<br><br>Сүүлийн хагас жилд: Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 63.0 хувьд хүрсэн байна. | I-IV | |
| 84. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.4 дүгээр арга хэмжээ-Мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй, чанартай гүйцэтгэж, нотлох баримт дутуу, хуульд заасан үндэслэл журмын дагуу бэхжүүлээгүй гэх үндэслэлээр прокурор, шүүхээс эрүүгийн хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт явуулахаар буцсан хэрэг өмнөх оны мөн үеэс 5 хувиар бууруулах; /Алсын хараа 2050-5.6.6/ | МШХ | -Шүүх, Прокуророос буцсан хэргийн бүртгэл хөтлөгдсөн байх;<br>-Шүүх, Прокуророос буцсан хэргийн хувь буурсан байх;<br>-Хэргийн буцсан үндэслэлд дүгнэлт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулсан байх. | 2021 онд шүүх, прокуророос давхардсан тоогоор 341 хэрэг буцсан. Үүнээс 56 нь шүүхээс буцсан байна. Энэ нь Ковид-19 цар тахлын улмаас Засгийн газраас удаа дараа хатуу хөл хорио тогтоосноос мөрдөн шалгах ажиллагаа болон прокурорын байгууллага хуваариар ажиллаж байгаатай холбоотой үүссэн нөхцөл байдал гэж үзэж байна. | -Шүүх, прокурорын байгууллагаас нэмэлт мөрдөн байцаалтад буцсан хэрэгт бүртгэлээр хяналт тавьж, буцсан шалтгаан, нөхцөлийг тогтоосон байна.<br>-Шүүх, прокуророос буцсан хэргийн шалтгааныг тогтоож, үндэслэлгүй тогтоолд тухай бүр санал бичих, нэмэлт ажиллагаа хийх зэргээр зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.<br>-Шүүх, прокуророос буцсан хэргийн тоо, шилжүүлсэн хэрэгт эзлэх хувь буурсан байна. | I-IV | |
| 85. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.5 дугаар арга хэмжээ-Шүүхэд шилжүүлсэн, шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн тоо, эзлэх хувийг нэмэгдүүлэх;<br>/Алсын хараа 2050-5.6.6/ | МШХ | Хэргийн нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоож, шүүхэд шилжүүлсэн болон шийдвэрлэгдсэн хэргийн хувь өссөн байх; | Тайлант хугацаанд хуульд заасан харьяаллын 1543 үйлдэлтэй, 909 холбогдогчтой, 1307 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 269 буюу 20.6 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, шүүхэд шилжүүлэх саналтай хэргийн хувь 2.9 хувиар өссөн байна.<br>2021 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлсэн хэргээс 160 /59.4 хувь/ хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 40.3 хувиар өссөн байна. | Шийдвэрлэсэн хэргийн дотор шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн хэргийн эзлэх хувийг урьд оноос ахиулж 21,0 хувьд хүргэсэн байна.. | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 86. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.6 дугаар арга хэмжээ-Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, олсон орлого, нуугдмал өмч, хөрөнгийг илрүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хөрөнгийг битүүмжлэн хамгаалах арга хэмжээг авч хохирол нөхөн төлүүлэлтийг урьд оны мөн үеэс нэмэгдүүлэх;<br>/Алсын хараа 2050-5.6.6/ | МШХ | -Мөрдөн байцаалтын хэрэгт бүрт учирсан хохирлыг бүрэн тогтоосон байх<br>-Хохирол учирсан байгууллага, иргэнийг хохирогч иргэний нэхэмжлэгчээр тогтоож мэдүүлэг авсан байх;<br>-Хэрэг бүрт хөрөнгө хамгаалах, хязгаарлах битүүмжлэх ажиллагааг хийж, түвшинг ахиулсан байх; | 2021 онд шалгасан гэмт хэргийн улмаас 1,002,100,805, 191 /нэг их наяд, 2 тэрбум, нэг зуун сая, найман зуун таван мянга нэг зуун ерэн нэг/ төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 96,207,070,220 /ерэн зургаан тэрбум, хоёр зуун долоон сая, далан мянга, хоёр зуун хорь/ төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 119,502,691,958 /нэг зуун арван есөн тэрбум, таван зуун хоёр сая, зургаан зуун ерэн нэгэн мянга, есөн зуун тавин найм/ төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлт 2.7 дахин өссөн үзүүлэлттэй байна. | Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээг 5.0 хувиар ахиулсан байна. | I-IV | |
| 87. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.7 дугаар арга хэмжээ-Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар мөрдөгчийн мэдэгдэл бичих, үр дүнг тооцох чиглэлээр УССГХ-тэй хамтран ажиллах; | МШХ | -Шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн хэргийн 50-иас дээш хувьд нь гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хамжээ авахуулахаар мөрдөгчийн мэдэгдэл бичсэн байх;<br>-Үр дүнг УССГХ-тэй хамтран тооцсон байх; | 2-021 онд эрх бүхий албан тушаалтанд мөрдөгчийн 162 мэдэгдэл бичиж, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хууль хэрэгжүүлэх, зөрчил арилгуулах, авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авхуулахаар 61 албан бичгийг хүргүүлсэн. Шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн хэргийн 60.2 хувьд мэдэгдэл, бичсэн үзүүлэлттэй байна. | -"Авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох аргачлал"-ын дагуу мөрдөгч бүр мэдэгдэл бичиж, энэ ажлын гүйцэтгэлийг мөрдөгч бүрээр гаргаж үр дүнг тооцож ажиллах ;<br>-Шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн хэргийн 50-иас дээш хувьд нь мөрдөгчийн мэдэгдэл бичсэн байх;<br>-Мэдэгдлийн хариуг мэдэгдэл хүргүүлсэн хуулийн этгээдээс хүлээн авч, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байх; | **I-IV** | |
| 88. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.8 дугаар арга хэмжээ-Гомдол, мэдээлэл, гэмт хэргийн тоо бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөх, шаардлагатай тайлан мэдээг гаргах, дүн шинжилгээ хийх; | МШХ | -Цахим санд гомдол, мэдээллийн үнэн зөв, бүрэн оруулж хэвшсэн байх;<br>-Тогтоосон хугацаанд цахим сангаар дамжуулан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, гэмт хэргийн тайлан, мэдээг гаргаж, ҮСХ, эрх бүхий бусад байгууллагад хүргүүлсэн байх;<br>-Мэдээ, тайланд үндэслэн сар тутамд танилцуулга, мэдээлэл бэлтгэгдэж танилцуулагдсан байх;<br>-Мөрдөгчид санд мэдээллийг оруулах мэдлэг, чадвартай болсон байх;<br>-Санд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн шаардлагатай мэдээ, судалгаа гардаг болсон байх; | -2020.01.01-ний өдрөөс шинэ цахим санг үйл ажиллагаанд нэвтрүүлсэнтэй холбогдуулан батлагдсан маягтын дагуу гомдол мэдээлэл, гэмт хэргийн тоо үзүүлэлтийг тухай бүр гаргаж улсын нэгдсэн статистикийг бүрдүүлэхийн зэрэгцээ албан хаагчдын үйл ажиллагаанд цахимаар хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. Албан хаагчдад цахим санд ажиллах арга зүйн чиглэлээр сургалт зохион байгуулж, хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийг тухай бүр цахимаар танилцах, хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. 7 хоног тутамд хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч байна. | Гэмт хэргийн мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулж, програмын бүртгэлээр дамжуулан албан хаагчдын үйл ажиллагаанд тавих хяналт сайжирсан байна. | **I-IV** | |
| 89. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.9 дүгээр арга хэмжээ-Шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн хэргийн хэргийн шийтгэх тогтоолын сан бүрдүүлэх; | МШХ | Шийтгэх тогтоолын хуулбарыг тухай бүр авсан байх | 2021 оны шийдвэрлэгдсэн 160 эрүүгийн хэргийн 116 эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолыг прокурор, шүүхийн байгууллагуудаас хуулбарлан авч сан бүрдүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна. | | **I-IV** | |
| Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт / 3.2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг/<br>Нийтлэг чиг үүрэг-Төрийн захиргааны удирдлага | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Гүйцэтгэлийн зорилт №3.1.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх; | | | | | | | |
| 90. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.1 дүгээр арга хэмжээ-Албан хаагчдын дунд биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах; | ТХ Спорт хамтлаг | -Төлөвлөгөө батлагдсан байх;<br>-Спортын уралдаан, тэмцээнийг зохион байгуулсан байх;<br>-Бусад байгууллагуудаас зохион байгуулж байгаа тэмцээн уралдаанд оролцсон байх; | Албан хаагчдын дунд биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулж ирсэн. | 1 дүгээр улиралд -Төлөвлөгөө батлагдсан байх;<br>1-4 дүгээр улиралд -Спортын уралдаан, тэмцээнийг зохион байгуулсан байх;<br>-Бусад байгууллагуудаас зохион байгуулж байгаа тэмцээн уралдаанд оролцсон байх; | I-IV | |
| 91. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.2 дугаар арга хэмжээ-Төрийн албаны стандартын удирдлагын хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бусад ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх; | ТХ | -Албан хаагчидтай холбоотой бүх төрлийн судалгаа хийгдэж, эрх бүхий байгууллагад шаардлагатай мэдээ, судалгаа хүргэгдсэн байх;<br>-Албан хаагчийн төрийн алба хаах болон хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудал зохих журмын дагуу шийдвэрлэгдэж, албан хаагчийн эрх ашиг хамгаалагдсан байх;<br>-Зохих бүртгэл хөтлөгдсөн, хувийн хэрэгт баяжилт хийгдсэн байх;<br>-Стандартын удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардагдах бусад ажил, арга хэмжээг зохих журмын дагуу хэрэгжүүлсэн байх;<br>-Албан хаагчдыг албан тушаалд томилох, чөлөөлөх, хүний нөөцийн судалгаа, сонгон шалгаруулалт зохих журмын дагуу явагдсан байна.<br>-Албан хаагчдын болон иргэдийн өргөдөл, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэсэн байна. | Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу зохих арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн. Төрийн албаны тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ батлагдсанаар зарим бүртгэл, судалгааг шинэчлэх, шинээр боловсруулах шаардлагатай байгаа.<br>-Хүний нөөц, хүний нөөцийн хөгжил, нийгмийн хамгааллын талаарх шаардлагатай мэдээлэл бэлтгэх, эрх бүхий албан тушаалтныг тухай бүр мэдээллээр хангасан байна. | -Төрийн болон бусад, яам агентлаг, бусад байгууллагын болон АТГ-ын шагналд албан хаагчдыг тодорхойлох, нэр дэвшүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэх;<br>-Хариуцлага ногдуулсан албан хаагчдын нэгдсэн бүртгэл хөтлөх;<br>-Төрийн албаны болон хөдөлмөрийн харилцаатай холбоотой шийдвэрүүд зохих журмын дагуу албажсан байна. /тусламж дэмжлэг үзүүлсэн, тусламж, дэмжлэг, хөнгөлөлт үзүүлсэн албан хаагчдын, төрийн болон цэргийн алба хаасан хугацааны, сургалтад хамрагдсан гэх зэрэг/<br>-Албан хаагчийн нөөцийн бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлсөн байх;<br>-Албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын хэрэгжилт хангагдсан байна.<br>-Төрийн албаны зөвлөлд албан хаагчийн хөдөлгөөний мэдээ зохих журмын дагуу хугацаандаа хүргэгдсэн байна.<br>-Бусад судалгаа бүрэн хийгдсэн, үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдсэн байна.<br>-Хүний нөөц, сургалтын чиглэлээр хэлтэс, албадад зөвлөмж, мэдээллийг хүргүүлсэн байна.<br>-Албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг хангах, архивт шилжүүлэх шаардлагатай хувийн хэргийг зохих журмын дагуу жил тутамд архивт шилжүүлсэн байна. | I-IV | |
| 92. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.3 дугаар арга хэмжээ-Байгууллагын дотоод зохион байгуулалтын ажлыг хариуцан гүйцэтгэх; | ТХ | -Байгууллагын дотоод ажлыг хариуцан гүйцэтгэсэн байх;<br>-Зөрчил дутагдал гаргаагүй байна. | Хэлтэс, албадын үйл ажиллагааны уялдааг хангаж дотоод зохион байгуулалтыг хариуцан гүйцэтгэх Тамгын хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа. | -Дотоод мэдээллийн цаг тогтмолжсон байна.<br>-Хэлтэс, албад шаардлагатай мэдээ, мэдээллээр тухай бүр хангагдсан байна.<br>-Хэлтсийн болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэлийг тухай бүр зохих журмын дагуу гаргаж, хяналт үнэлгээ хийсэн байх, зөвлөмжийг хэлтэс, албадад хүргүүлсэн байна.<br>-Даргын зөвлөлийн болон шуурхай зөвлөгөөн, байгууллагын удирдлага, зохион байгуулалтын хүрээнд хийгдэж байгаа хурал, зөвлөгөөний бэлтгэл ажлыг хангаж, явцыг болон шийдвэрийг зохих журмын дагуу албажуулсан байна.<br>-Шийдвэр болон үүрэг даалгаврын гүйцэтгэлийг нэгтгэн боловсруулж, авах арга хэмжээний санал танилцуулж шийдвэрлүүлж байна. | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Байгууллагын танилцуулга болон бусад шаардлагатай танилцуулга, мэдээллийг нэгтгэн боловсруулсан байна.<br>-УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрээр батлагдсан бодлогын баримт бичгийн гүйцэтгэлийг нэгтгэн боловсруулах, эрх бүхий байгууллагад зохих журмын дагуу хүргүүлсэн байна. | | |
| Гүйцэтгэлийн зорилт №3.1.1.2 Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 93. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.4 дүгээр арга хэмжээ-Байгууллагын архивыг бүрдүүлэх; | ТХ | - Архивын жилийн ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулан биелэлт, жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээний биелэлтийн талаар тайлан гаргасан байх;<br>-Архивын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу эмхлэн цэгцлэгдсэн баримтуудыг хүлээн авсан байх;<br>-Тухайн жилд зохион бүрдүүлсэн баримтуудыг бүрдүүлж, нэгж үүсгэн архивт шилжүүлсэн байдлыг шалгаж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авсан байх;<br>-Архивт хүлээн авсан баримтад тоо бүртгэлийн үндсэн болон туслах баримт бичиг хөтөлсөн байх;<br>-Байгууллагын удирдлага, хэлтэс, албад, бусад этгээдийг архивын мэдээллээр хангасан байх;<br>-Байгууллага, иргэдийн -Хадгаламжийн нэгжийн тоо бүртгэл хөтөлсөн байна хүсэлтээр архивын лавлагаа олгосон байх;<br>-2021 онд үүсч хөтлөгдсөн баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байх;<br>-ХХНЖ-ыг боловсруулж батлуулсан байх;<br>-Баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтад баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах зорилго бүхий байгууллагын дэргэдэх ББНШ хуралдааны бэлтгэл ажлыг хангах, гарсан шийдвэр, үйл явцыг албажуулж, бүртгэл хөтөлсөн байх;<br>-Хадгаламжийн санд баримтуудыг зохих журмын дагуу байршуулсан байх;<br>-Хадгаламжийн нэгжийн тоо бүртгэл хөтөлсөн байх;<br>-Тухайн жилд Төв архивт шилжүүлбэл зохих баримтуудын | Байгууллагын 2021 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж, 2020 онд үүсч хөтлөгдсөн нийт 1341 /Тамгын хэлтэс 119, УССГХ 24, ХШДШХ 1061, МШХ 51, АБХШНА 9, САAA 70, СШA-7/ баримтыг хүлээн авч, архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, нийтлэг журмыг баримтлан бүртгэлд оруулж, нэгж үүсгэсэн. Байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комиссын хуралдааныг 2 удаа зохион байгуулж, 2007-2016 оны баримтын /байнга хадгалах, байгууллагад байнга хадгалах, түр хадгалах, устгах/ данс, бүртгэлийг Үндэсний төв архивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссоор батлуулав.<br>Байгууллагын архивын баримт бичгийн эрэлт хайлтын үйл ажиллагааг боловсронгуй болгох чанарын шинэ шатанд гаргах Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндсэний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагад байнга хадгалдаг захирамжлалын баримт бичиг / “А”, “Б” тушаал 596 хуудас, Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгчийн санал 4108 хуудас баримт/-ийг цахим хэлбэрт оруулж бүртгэлжүүлэв.<br>Байгууллагын архивын баримтыг ашиглах журмын дагуу архивын 54 хадгаламжийн нэгжээс 189 хуудас баримт, цахим архивын 203 хадгаламжийн нэгжээс 680 хуудас баримтыг албан хэрэгцээнд ашиглуулахаар бүртгэлээр шилжүүлсэн. Мөн 210 боть хадгаламжийн нэгжийг албан хэрэгцээнд ашиглуулахаар бүртгэлээр шилжүүлсэн.<br>Нийт 53048 хэвлэмэл хуудсыг дугаарлаж, бүртгэлээр тараан, тооцоог тухай бүр хийж, хяналт тавин ажиллав.<br>Байгууллагын дэргэдэх БНШК-ын хуралдааны бэлтгэл ажлыг хангаж комисс нийт 2 удаа хуралдсан. Хуралдаанаар Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл-1 данс 2007-2013 он, Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл-2 данс 2014-2016 он, Түр хадгалах хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл 2007-2016 он, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, Байгууллагад байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, - Устгах баримтын жагсаалт 2007-2016 он гэсэн бүртгэлийг хянан хэлэлцлээ. | -Архивын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэлтэс, албадаас эмхлэн цэгцлэгдсэн баримтуудыг хүлээн авсан байна.<br>-Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж батлуулсан байна.<br>-2020 онд үүсч хөтлөгдсөн баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.<br>-Тухайн жилд зохион бүрдүүлсэн баримтуудыг бүрдүүлж, нэгж үүсгэн архивт шилжүүлсэн байдлыг шалгаж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авсан байна.<br>-2020 онд үүсч хөтлөгдсөн баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.<br>-Баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтад баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах зорилго бүхий байгууллагын дэргэдэх ББНШК-ын хуралдааны бэлтгэл ажлыг хангах, гарсан шийдвэр, үйл явцыг албажуулж, бүртгэл хөтөлсөн байна. /жилд 2 удаа/ -Тухайн жилд Төв архивт шилжүүлбэл зохих баримтуудын жагсаалт гарган бүрдлийг хангаж шилжүүлсэн байна.<br>-Байгууллагын удирдлага, хэлтэс, албад, бусад этгээдийг архивын мэдээллээр хангасан байна.<br>-Байгууллага, иргэдийн хүсэлтээр архивын лавлагаа олгосон байна.<br>-Баримтын хадгалалтын горимд хяналт тавьж, шаардлага хангуулах арга хэмжээ авсан байна.<br>-Архивт хүлээн авсан баримтад тоо бүртгэлийн үндсэн болон туслах баримт бичиг хөтөлсөн байна. -Хадгаламжийн санд баримтуудыг зохих журмын дагуу байршуулсан байна. | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | жагсаалт гарган бүрдлийг хангаж шилжүүлсэн байх; | | | | |
| 94. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.5 дугаар арга хэмжээ-“Хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх хадгалах журам”-ын хэрэгжилтийг хангах | ТХ | -Хэвлэмэл хуудасны бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлсөн байх;<br>-Хэвлэмэл хуудсыг зохих журмын дагуу хадгалж, зарцуулалт, устгалын бүртгэлийг хөтөлсөн байх;<br>-Хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг зохих журмын дагуу хагас, бүтэн жилээр тайлагнаж, санхүүтэй тооцоо нийлсэн байх;<br>-Зөрчил дутагдал гаргаагүй байх; | Нийт 53048 хэвлэмэл хуудсыг дугаарлаж, бүртгэлээр тараасан. Хэвлэмэл хуудасны зарцуулалт, устгалын бүртгэлийг зохих журмын дагуу тогтмол хийж, тайланг сар тутамд гарган тооцоо санхүүтэй нийлэн ажиллаж байна. | -Хэвлэмэл хуудасны бүртгэл, тооцоо, захиалга зохих журмын дагуу хийгдсэн байна. | I-IV | |
| 95. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.6 дугаар арга хэмжээ-Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг Төрийн албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн стандарт холбогдох бусад эрхийн актын дагуу хөтлөх, хариуцан ажиллах; | ТХ | -Байгууллагад ирсэн баримт бичгийг хүлээн авах, ангилах, бүртгэх, холбогдох ажилтанд шилжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэсэн байх;<br>-Явуулах баримт бичгийг хүлээн авч, бүрдлийг шалгах, бүртгэх, дугтуйлах, хаяглах, илгээх ажлыг хариуцан гүйцэтгэсэн байх;<br>-Баримт бичгээр тавьсан асуудлын шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, үр дүнг удирдлагад мэдээлэх, шийдвэрлэх хугацаа хэтэрсэн баримт бичиг, өргөдөл гомдлын мэдээг тогтмол гаргасан байх;<br>-Байгууллагын үйл ажиллагаанд үүсч хөтлөгдсөн баримт бичиг, мэдээллийг ангилах, төрөлжүүлэх, мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулсан байх;<br>- Иргэдийн болон албан хаагчдын гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих, мэдээ, тайлан гаргах ажлыг зохион байгуулах;<br>-Бичиг хэрэгт төвлөрөн хадгалагдаж буй баримт бичгийг дараа оны эхэнд ангилан төрөлжүүлж, хэрэг бүрдүүлэх, байнга хадгалах баримт бичигт архив зүйн боловсруулалт хийж, байгууллагын архивт шилжүүлэх ажлыг зохион байгуулсан байх;<br>-Зохион байгуулалтын нэгжүүдийн албан хэрэг хөтлөлт, баримт бичигтэй ажиллах ажиллагаанд хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангах;<br>-Баримт бичгийн эргэлтийн нийт тоо хэмжээ, өөрчлөлт, хөдөлгөөнийг нэгтгэн, хагас, бүтэн жилээр танилцуулсан байх; | Байгууллагын хэмжээнд 2021 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас гаргасан 2314 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авснаас Мөрдөн шалгах хэлтэст 1491 буюу 64,4 хувь, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст 560 буюу 24.2 хувь, Гүйцэтгэх ажлын хэлтэст 194 буюу 8,4 хувь, Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын албанд 43 буюу 1.9 хувь, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст 26 буюу 1,1 хувь нь тус тус хуваарилагдан хянан шалгагдсан байна.<br>Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, өргөдөл, гомдол, мэдээлэл 32 нэгжээр буюу 1,4 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 78 нэгжээр буюу 6.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>7 хоног тутамд байгууллагад хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэл, албан бичгийн судалгаатай танилцан авах арга хэмжээг тодорхойлон ажиллаж байна. | -”Төрийн албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.<br>-Зөрчил дутагдал гаргаагүй байна. | I-IV | |
| 96. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.7 дугаар арга хэмжээ-Төрийн албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн стандарт холбогдох бусад эрхийн актын дагуу удирдлагын | ТХ | -Удирдлагын үйл ажиллагаанд ашиглаж буй баримт бичгийг зохих журам, стандартын дагуу хөтөлж, бүрдүүлсэн байна.<br>-Цахим баримтыг холбогдох программ хангамж, техник хэрэгслийг ашиглан боловсруулсан байх;<br>-Байгууллагын үйл ажиллагааны холбогдолтой баримт бичгийг боловсруулах, зохион бүрдүүлэх, ёсчлохдоо албан хэрэг хөтлөлтийн | 2021 онд иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор 361 гэрээ байгуулагдсан байна. Байгууллагын хэмжээнд А тушаал 73, Б тушаал 97 батлагдсан байна. Бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 14103 албан бичиг хүлээн авч, бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 14214 албан бичиг илгээн, орон нутгийн шууданд болон бусад албан байгууллагад давхардсан тоогоор 17976 бичиг баримт хүргэсэн үзүүлэлттэй байна. Эдгээр үзүүлэлтийг | -Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар” болон бусад эрхийн актын хэрэгжилт бүрэн хангагдсан байна.<br>-Зөрчил дутагдал гаргаагүй байна. | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрийг албажуулах, арга зүйн зөвлөгөөгөөр хангах; Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.8 дугаар арга хэмжээ-Удирдлагын хүчин төгөлдөр баримт бичгийг байгууллага, албан тушаалтан, иргэдэд хүргэх, хүлээн авах; | | цуврал стандартад тодорхойлсон техникийн шаардлагуудыг мөрдлөг болгосон байх;<br>--Удирдлагын баримт бичгийг зохион бүрдүүлэхдээ холбогдох хэлтэс, нэгж, албан тушаалтнуудаас виз авч, шаардлагатай тохиолдолд танилцуулга хийж хавсаргасан эсэхийг хянаж бүрдлийг бүрэн хангасан байх;<br>-Батлагдсан тушаал, бусад захирамжлалын баримт бичгийг бүртгэн, хувилж олшруулан холбогдох хэлтэс, албад, албан хаагчид шуурхай хүргүүлж бүртгэл хөтөлсөн байх;<br>-Байгууллагын үндсэн үйл ажиллагааны талаар гарсан тушаалд оны эхнээс нэгдсэн дугаар өгч, холбогдох албан тушаалтанд хүргүүлэн төвлөрсөн журмаар бүртгэл хөтөлсөн байх;<br>-Баримт бичгийг компьютерт боловсруулах, компьютерын санамжид баримт бичгийг эмх цэгцтэй хадгалах, ашиглах талаарх журмын хэрэгжилт хангагдсан байх;<br>-Гэрээг дугаарлах, бүртгэх журмыг хангуулж, цахим бүртгэл хөтөлсөн байх; | өмнөх оны мөн үетэй харьцуулбал, иргэн, хуулийн этгээдээс хүлээн авсан бичиг 357 /13530/ нэгжээр буюу 2,6 хувиар, бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн албан бичиг 573 /13857/ нэгжээр буюу 4,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тогтоосон хугацаанд 2020 онд үүсч хөтлөгдсөн гэрээ, тушаалыг эмхлэн архивт шилжүүлсэн.<br>2020 онд байгуулсан гэрээг PDF-ээр цахимд шилжүүлж, үйл ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүллээ. | | | |
| Гүйцэтгэлийн зорилт № 3.2 Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх; | | | | | | | |
| 97. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.1 дүгээр арга хэмжээ-Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн актуудыг боловсронгуй болгох, холбогдох хууль, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах чиглэлээр санал боловсруулах; | ТХ | -Эрхийн акт, нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсрогдсон байх;<br>-Төслийг хэлтэс, албад, албан хаагчдад танилцуулж, санал авсан байх;<br>-Төсөл албажиж, үйл ажиллагаанд мөрдөгдсөн байх;<br>-Албан хаагчдад танилцуулж, үйл ажиллагаанд мөрдөх боломжийг бүрдүүлсэн байх;<br>-Эрхийн актуудын цахим сан үүсгэж, албан хаагчид ашиглах боломжийг бүрдүүлсэн байх;<br>-Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг улсын нэгдсэн бүртгүүлэх арга хэмжээ авсан байх;<br>-Хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаарх саналыг боловсруулах, санал авах, нэгтгэн боловсруулах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, судалгаа хийлгэх зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэх; | Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.9 дэх хэсэгт заасны дагуу боловсруулсан “Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журам”, “Хамгаалалтын арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх байгууллагатай ажиллах гэрээ”, “Гэрч хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамтран ажиллах гэрээ”,“Насанд хүрээгүй гэрч, хохирогч, хамгаалалтын арга хэмжээнд хамтран ажиллах гэрээ”, “Нууцлал, аюулгүй байдлыг хангах гэрээ”, “Баримт бичиг солих тухай гэрээ, “Гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчлөх хамгаалалтын арга хэмжээний гэрээ”-ний төсөл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийтийн мэдээллийн тухай хуулийн төслүүдэд тусгавал зохих саналуудыг боловсруулан ХЗДХЯ болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлав. Эрх зүйн акт эмхлэх хүрээнд шаардлагатай эрхийн актуудыг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг тогтмол хийж, тайлант хугацаанд “Хүүхдийн шударга байдлын судалгааны удирдамж”, “Албан бичгийн индекс тогтоох тухай”, “Авлигатай тэмцэх газрын тээврийн хэрэгсэл ашиглах журам”-д холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулж, “Гамшгаас хамгаалах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 2014 оны А/76, “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” 2015 оны А/25, “Автомашин ашиглалтын хуваарь, шатахуун зарцуулалтын жишиг нормыг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны А/95 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн алба хаасан хугацааг тооцох тушаалыг албажуулав. | -Эрхийн акт, нэмэлт өөрчлөлт батлагдаж, үйл ажиллагаанд мөрдөгдсөн байна.<br>Эрх бүхий байгууллага, албан тушаалтанд санал уламжлагдсан байна | I-IV | |
| 98. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.2 дугаар арга хэмжээ-Хариуцагчийн | ТХ | -Хариуцагчийн төлөөллийг хэрэгжүүлсэн байх;<br>-Төлөөлөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан шүүхэд болон | Нийтийн албан тушаалд нэр дэвшигч нь тухайн ажлын байранд тавигдах шаардлага хангахгүй байгаа болон ашиг сонирхлын зөрчилтэй гэх шийдвэр гаргасан, мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг | -Шүүх болон төрийн бусад байгууллагад төлөөлөл хэрэгжүүлсэн байх;<br>-Мэдээллийн сан бүрдсэн байх; | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөөллийг шүүх болон бусад байгууллагад хэрэгжүүлэх; | | бусад эрх бүхий байгууллагад хүргүүлэх нэхэмжлэл, гомдол, тайлбар, нотлох баримтын хууль зүйн үндэслэлийг боловсруулах, журмын дагуу хүргүүлсэн байх;<br>-Шүүхээр болон бусад эрх бүхий байгууллагаас шийдвэрлэсэн хэрэг, маргаан бусад үйл ажиллагааны мэдээллээр сан үүсгэх, баримт материалыг эмхлэн архивын нэгж үүсгэх, албан хаагчдын хувийн хэрэгт шаардлагатай баримтуудаар баяжилт хийсэн байх;<br>-Шийдвэрлэсэн хэрэг маргаантай холбогдуулан зөвлөмж боловсруулан хэлтэс, албадад хүргүүлсэн байх;<br>-Хуульд заасан журмын дагуу төрийн байгууллагын хүсэлтийг эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байх; | зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулиар тогтоосон хориглолт, хязгаарлалтыг болон Авлигын эсрэг хуулийг зөрчсөн гэх үндэслэлээр сахилгын арга хэмжээ авагдсантай холбогдуулан мөн төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбогдох асуудлаар Захиргааны шүүхэд гомдол гаргасан нэр бүхий 2 иргэний, мөн АТГ-аас төрийн албаны харилцаатай холбогдуулан гаргасан захиргааны акттай холбогдуулан 2 иргэнээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон ажиллуулав. Шүүх хуралдаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тус бүрт хариу тайлбар, давж заалдах шатны шүүхэд гомдол, тайлбар гаргах, баримт хүргүүлэх болон холбогдох бусад хуульд заасан ажиллагаануудыг зохих журмын дагуу хийлээ. Нийтийн албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэлгүй, "Шүүгчийн ёс зүйн дүрэм"-ийг зөрчсөн 22 шүүгчид холбогдох зөрчлийг илрүүлэн журмын дагуу шийдвэрлүүлэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн ёс зүйн хороонд гомдол гаргаснаар нэр бүхий 10 шүүгчийг ёс зүйн зөрчил гаргасныг тогтоож шийдвэрлэсэн. Бусад шүүгчдэд холбогдох гомдлыг хянан хэлэлцэх ажиллагаа үргэлжилж байна. | -Төлөөлөл хэрэгжүүлэхэд гарсан асуудлаар эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө, зөвлөж өгсөн байх; | | |
| 99. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.3 дугаар арга хэмжээ-Хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө өгөх; | ТХ | -Заавар зөвлөмж, арга зүйн туслалцааг улирал тутамд боловсруулж хүргүүлсэн байх;<br>-Шалган зааварлах, зөвлөх удирдамж, төлөвлөгөө батлагдаж гүйцэтгэл хангагдсан байх;<br>-Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлага хангуулах арга хэмжээ авсан байх;<br>-МШХ-т хамаарах гэрээний эх бэлтгэх, бусад хэлтэс, албадаас байгуулах гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авсан байх; | 2021 онд иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор 361 гэрээ байгуулагдсан байна. Байгууллагын хэмжээнд А тушаал 73, Б тушаал 97 батлагдсан байна. Захиргааны акт боловсруулах, батлах, гэрээ байгуулахтай холбоотой мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч, хяналт тавин ажиллаж байна. МШХ-ийн үйл ажиллагаанд хамаарах гэрээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан шилжүүлж, бусад гэрээний болон тушаал бүрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, хуульд нийцүүлэх арга хэмжээг авч ажиллав.<br>Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны талаар 3 удаагийн зөвлөмж хүргүүлж, шинээр томилогдсон албан хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. | -Захиргааны акт, захиргааны болон бусад гэрээ хууль тогтоомжид нийцсэн байна.<br>-Хэлтэс, албадын үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж явагдахад дэмжлэг үзүүлсэн байна. | I-IV | |
| Гүйцэтгэлийн зорилт №3.3. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх; | | | | | | | |
| 100. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.3.1.1 дүгээр арга хэмжээ-Авлигын индексийн төсөөллийн | ТХ | -Уулзалт, хэрэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулагдсан байх; | •Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 120 дугаар захирамжаар байгуулсан Авлигын индексийг бууруулах ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд Авлигатай тэмцэх газрын эрх бүхий албан хаагчид, төлөөлөгчид Берлин хотод 10 дугаар | АТИ-ийг боловсруулахад ажилладаг 9 эх сурвалж байгууллагатай уулзалт зохион байгуулж Монгол Улсын авлигын эсрэг үйл ажиллагааг танилцуулж, хамтын ажиллагааны санал солилцсон байна. | III-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | индексийг тодорхойлоход нөлөө үзүүлэх 9 шалгуур үзүүлэлт (индекс)-ийг тодорхойлоход оролцдог байгууллагуудтай хамтран ажиллах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, цаашдын хийх ажлыг тодорхойлох ажлыг тогтмолжуулах; | | | сарын 6-ны өдөр Транспаренси Интернейшнл байгууллагын гүйцэтгэх захирал Даниел Эрикссон, Азийн бүс нутаг хариуцсан зөвлөх Илхам Мохаммед, судалгааны ажилтан Роберто Кукучка, 10 дугаар сарын 8-ны өдөр Бертелсман сангийн ТУЗ-ын ахлах зөвлөх Стефан Эмпте, Монгол Улсыг хариуцсан судлаач Сабине Доннер нартай тус тус албан уулзалт хийж, Авлигын төсөөллийн индексийн талаар санал солилцов. | | | |
| 101. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.3.1.2 дугаар арга хэмжээ-Папуа Шинэ Гвиней Улсын хамтаар Самоа Улсын Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 2 ба 5 дугаар бүлгийн хэрэгжилтэд үнэлгээ хийх; | ТХ | 5 дугаар бүлэгт хамаарах, үнэлгээ, тайланг хүргүүлсэн байх; | 2021 онд Монгол Улс нь Папуа Шинэ Гвиней Улсын хамтаар Самоа Улсын Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 2 ба 5 дугаар бүлгийн хэрэгжилтэд үнэлгээ хийхээр сонгогдсон. Тус үнэлгээг хариуцаж буй НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны нарийн бичгийн газарт Монгол Улс 5 дугаар бүлгийг сонгох, англи хэлээр үнэлэх, мөн оролцогч талуудад боломжтой хугацаанд үнэлгээний ажилд оролцох талаарх саналаа хүргүүлсэн болно. | -НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны нарийн бичгийн газраас гаргасан хуваарийн дагуу ажиллаж, тогтоосон хугацаанд үнэлгээг хийж, тайланг хүргүүлсэн байх; | I-IV | |
| 102. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.3.1.3 дугаар арга хэмжээ-Хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх, хамтын ажиллагаатай байгууллагатай бүх чиглэлээр хамтран ажиллах ажил, арга хэмжээг хариуцан зохион байгуулах; | ТХ | -Олон улсын Авлигын эсрэг академиас зохион байгуулах Бүс нутгийн зуны сургалтад алба хаагчдыг хамруулсан байх; Бүс нутгийн зуны сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулах талаар судалж, Академитай харилцах.<br>-Бүгд найрамдах Азербайджан улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Авлигын эсрэг газартай байгуулсан “Санамж бичиг”-ийн хүрээнд албан хаагчдыг авлигын хэргийг мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад хамруулах, туршлага судлуулах ажлыг зохион байгуулсан байх;<br>-БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Авлигатай тэмцэх бие даасан хороотой хамтран авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан байх;<br>-БНХАУ-ын Үндэсний хяналтын хороотой албан ёсны харилцаа тогтоож, хоёр талын хамтын ажиллагааны талаар санал солилцох;<br>-Тайландын Авлигын эсрэг үндэсний хороотой байгуулсан санамж бичгийн хугацааг дууссан тул хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж танилцуулах, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байх; | Байгууллагын үйл ажиллагааг сурталчлан, таниулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсад суугаа АНУ, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Канад, Австралийн Холбооны Улсаас Монгол улсад суугаа элчин сайд нар, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны суурин төлөөлөгч нарыг хүлээн авч, албан уулзалтуудыг зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааг танилцуулав. Эрх бүхий албан хаагчид НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны “Торгоны замын эдийн засгийн бүс дагасан улсуудад Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилтийг хангах замаар тогтвортой хөгжлийг бий болгох нь” төслийн Нээлтийн хурал, Дэлхийн банкны Монгол Улстай байгуулах 2025 он хүртэлх дараагийн Түншлэлийн стратеги боловсруулж байгаатай холбогдуулан зохион байгуулсан төрийн байгууллагуудын зөвлөлдөх уулзалт, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын оролцогч талуудын чуулган, Хөрөнгө буцаах байгууллага хоорондын Төв Азийн бүс нутгийн хуралд оролцов. Транспаренси Интернейшнл байгууллагын гүйцэтгэх захирал Даниел Эрикссон, Азийн бүс нутаг хариуцсан зөвлөх Илхам Мохаммед, судалгааны ажилтан Роберто Кукучка, Бертелсман сангийн ТУЗ-ын ахлах зөвлөх Стефан Эмпте, Монгол Улсыг хариуцсан судлаач Сабине Доннер нартай тус тус албан уулзалт хийж, Авлигын төсөөллийн индексийн талаар санал солилцов. Түүнчлэн Авлигын эсрэг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Тусгай чуулганд, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын “Хэрэгжилтийг үнэлэх бүлэг”-ийн 12 дугаар удаагийн уулзалтын панел хэлэлцүүлэг, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас “Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ (GlobE)”-ний анхны Бүгд хурал, “Авлигын эсрэг олон улсын академийг олон улсын байгууллага болгон үүсгэн байгуулах тухай хэлэлцээр”-т оролцогч талуудын 10 дугаар чуулган, Зүүн европ, төв азийн Авлигын эсрэг сүлжээний 21 дүгээр удаагийн Бүгд хурлын үеэр Армени Улсын үнэлгээний тайланг батлах хуралдаанд, Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс “Нээлттэй төр түншлэл”-тэй хамтран 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Европын холбооны Зүүний түншүүд /Армени, Азербайжан, Беларус, Гүрж, Молдав, Украйн/-д зориулан зохион байгуулсан | -Шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох ажиллагааг санаачлан хэрэгжүүлсэн байна.<br>-Хамтын ажиллагааны хүрээ өргөжсөн байна. | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -Төрийн албаны ил тод, хариуцлагатай байдал, хүнд суртлыг бууруулах болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалттай холбоотой туршлага судлах, танилцах ажлыг Румын, Латви улсын авлигатай тэмцэх байгууллагатай харилцан тохиролцож, зохион байгуулсан байх;<br>-Олон улсын, бүс нутаг, хоёр талын хамтын ажиллагаатай улс орнууд болон олон улсын байгууллага хоорондын арга хэмжээ, хамтын үйл ажиллагаанд албан хаагчдыг оролцуулах ажлыг зохион байгуулсан байх;<br>-Олон улсын, бүс нутаг, хоёр талын хамтын ажиллагаатай улс орнууд болон олон улсын байгууллагын төлөөлөгчдийн уулзалт, хэлэлцээрийг зохион байгуулсан байх;<br>-Гадаад улс орны авлигатай тэмцэх, авлигын эсрэг байгууллагатай хамтын ажиллагаа тогтоох ажлыг судалж санал боловсруулсан, танилцуулж, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байх; | цахим хуралд тус тус оролцов. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн европ, төв азийн Авлигын эсрэг сүлжээний урилгаар Армени улсын авлигын эсрэг тогтолцоо, эрх зүйн орчинд бүрэн хэмжээний мониторинг хийх ажилд ажиглагчаар ажиллаж, дүгнэлт хүргүүллээ.<br>2021 онд Монгол Улс нь Папуа Шинэ Гвиней Улсын хамтаар Самоа Улсын Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 2 ба 5 дугаар бүлгийн хэрэгжилтэд үнэлгээ хийхээр болов. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалт, авлигын гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээр харилцан айлчлал хийх, туршлага солилцох талаар Румын Улсын Авлигын эсрэг удирдах газар болон Үндэсний шударга байдлын агентлагт санал хүргүүлснийг тус улсаас хүлээн авч, 2022 оны 01 дүгээр сард айлчлалыг зохион байгуулахаар бэлтгэл хангаж байна.<br>Казахстан Улсын Авлигатай тэмцэх газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газрын дэргэдэх Санхүүгийн их сургуультай авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахаар тохиролцож, Индонез улсын Авлигатай тэмцэх газар, Филиппин Улсын Омбудсманы байгууллагад хамтын ажиллагааны талаар хүсэлт хүргүүлсэн. Гэвч дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас дээрх байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу эдгээр ажиллагаа түр хойшлоод байна. | | | |
| Гүйцэтгэлийн зорилт №3.4. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах; | | | | | | | |
| 103. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.4.1.1 дүгээр арга хэмжээ-Авлигатай тэмцэх газраас авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаар хэвлэн нийтлэх, нийтлэл бичих, эрх бүхий албан тушаалтны хэвлэлд ярилцлага өгөх ажлыг зохион байгуулах; Хэвлэл, мэдээллийн байгууллага, редакциудтай хамтран ажиллах; | ТХ | -Мэдээ, баримт бэлтгэгдсэн байх;<br>-Хэвлэл мэдээллийн байгууллагаас санал ирүүлсэн болон байгууллагаас зохион байгуулж байгаа ажил, арга хэмжээг сурталчлах хүрээнд ярилцлага, тодруулга, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан байх;<br>-“Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ”, “Үндэсний шуудан”, “Өглөөний сонин” зэрэг өдөр тутмын сонинтой хамтран ажиллана. | Тайлант хугацаанд нийт 24 удаагийн “АТГ-ын мэдээлэл” нэвтрүүлэг буюу 480 минутын эфирийг MNB, Монголын мэдээ, UBS, Малчин, орон нутгийн телевизүүдээр бэлтгэн нэвтрүүлж, “АТГ-Олон нийтийн төв” фейсбүүк хуудсанд байршуулж, мөн байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах, мэдээлэх www.iaac.mn мэдээллийн хуудасны 1 дугаарыг эрхлэн хэвлүүлж, олны хүртээл болгов. Үндэсний өдөр тутмын “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сонинтой хамтран ажиллах гэрээ байгуулж, “Шударга ёс, хөгжил дэвшилд” тогтмол буланг нээж, нийт 7 нийтлэл, ярилцлага нийтлүүлсэн. “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сонинд Авлигатай тэмцэх газрын 2020 оны тайланг болон “Өнөөдөр”, “Үндэсний шуудан”, “Зууны мэдээ”, “Өглөөний сонин”, “Өдрийн сонин”-д мэдээ мэдээлэл, ярилцлага зэрэг нийт 16 мэдээллийг хэвлүүлж уншигчдад түгээж, нийтлэлийн нэгдсэн санг үүсгэлээ.Тайлант хугацаанд хэвлэлийн 198 мэдээг байгууллагын цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлүүлэн олон нийтэд түгээв. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлч, сурвалжлагч нартай тогтмол харилцаатай ажиллаж байна. Хэвлэл, олон нийттэй харилцах ажилтнууд АТГ-ын үйл ажиллагааны талаар | -Үнэн бодит мэдээллээр хангасан байна.<br>-Шаардлагатай бүхий л тохиолдолд ярилцлага, тодруулга, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан байна.<br>-Байгууллагын үйл ажиллагааны тайлан, танилцуулгыг vector дүрслэл бүхий мэдээлэл бэлтгэж, өдөр тутмын сонинд нийтлүүлнэ. Энэ нь ажлын тайланг сонирхолтой хэлбэрээр хүргэх нэг төрлийн мэдээлэл болно.<br>-Байгууллагаас зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг, өдөрлөг г.м арга хэмжээний талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэн сурталчлах ажлыг зохион байгуулна. | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хандсан сэтгүүлчдийн асуултад хариулт, тодруулга өгч ажиллав. | | | |
| 104. | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.4.1.2 дугаар арга хэмжээ-Авлигатай тэмцэх газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны талаар мэдээлэх “www.iaac.mn” мэдээллийн хуудсыг эрхлэн гаргах, түгээх; | ТХ | -“www.iaac.mn” мэдээллийн хуудсыг сар тутамд хэвлэн гаргасан байх;<br>-Мэдээллийн хуудсыг иргэдэд хүргэсэн байх; | Авлигатай тэмцэх газрын албан ёсны цахим хуудас /www.iaac.mn/-д үйл ажиллагааны тайлан мэдээг тухай бүр байршуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж байна. | -“www.iaac.mn” мэдээллийн хуудсыг сард 1удаа, нийт 12 удаа хэвлэн түгээсэн байх; | I-IV | |
